



УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан
(өөрөөр тайлагнаагүй бол мянган канад доллароор илэрхийлэв)

УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ
2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

Агуулга

	Хуудас
Компанийн танилцуулга	3
Онцлох үйл явдлууд	3
Стратеги, хэтийн төлөв	4
Баянхөндий уурхайн үйл ажиллагааны тухай	5
Хөндий Эрдсийн Дүүргийн нөөцийн тооцоолол	7
Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд	8
NI 43-101 техникийн тайлан – геологийн ба үйлдвэрлэлийн нөөц	8
Хөндий Эрдсийн Дүүрэг хайгуул	8
Хөрөнгө оруулалт	18
Үйл ажиллагааны хэлэлцүүлэг	18
Улирлын үр дүнгийн хураангуй	20
Төлбөр гүйцэтгэх чадвар болон хөрөнгийн эх үүсвэр	20
Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл	21
Гэрээгээр хүлээсэн үүрэг	21
Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг	22
Балансаас гадуурх зохицуулалт	22
Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж, тооцоолол	23
Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт	23
Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл	24
Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт	25
Мэргэшсэн этгээд	25
Бусад мэдээлэл	26
Хавсралт А – Баянхөндий эрдсийн нөөцийн тооцооллыг дэмжих техникийн мэдээлэл	
Хавсралт В – Хар Морь эрдсийн нөөцийн тооцооллыг дэмжих техникийн мэдээлэл	

Энэхүү 2026 оны 8 сарын 12-ны өдрийн байдлаар боловсруулсан Удирдлагын Хэлэлцүүлэг ба Дүн Шинжилгээ (“УХДШ”) нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” эсвэл “Корпораци” гэх)-ийн 2025, 2026 оны 6 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон гурав болон зургаан сарын аудитаар баталгаажуулаагүй хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлан, 2024, 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан тайлан, тэдгээрийн тодруулгуудын хамт уншигдана. Компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Канад доллараар илэрхийлж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулсан.

Энэхүү хэлэлцүүлэг нь “Урьдчилсан таамаглал” гэж үзэж болохуйц тодорхой мэдэгдлүүдийг агуулсан болно. Түүхэн баримтат мэдэгдлээс бусад энэхүү тайланд дурдагдах Баянхөндий ордын олборлолт болон нөөцийн боломж, хайгуулын өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагаа, төсөвт санхүүгийн үр дүн, компанийн хүлээж буй үйл явдал, хөгжүүлэлт зэрэг нь ирээдүйд чиглэсэн мэдэгдлүүд юм. Ийнхүү урьдчилсан таамаглал (Корпораци, түүний охин, хараат компаниудын тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа, эдийн засаг, зах зээлийн ерөнхий нөхцөл байдал, геополитикийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын зардал, үйл ажиллагааны зардал, валютын ханш, санхүүжилтийн боломж, тоног төхөөрөмжийн боломж, хүний нөөцийн боломж, ашигт малтмалын үнэ, бодит нөөц тогтоолт зэрэгтэй холбоотой төсөөллүүдийг багтаах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй)-д тулгуурласан ирээдүйд чиглэсэн мэдэгдлүүдэд илэрхийлсэн хүлээлтүүд нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй бөгөөд бодит үр дүн, хөгжүүлэлт нь зах зээлийн үнэ, хайгуул ба үнэлгээний үр дүн, капитал болон санхүүгийн тасралтгүй хүртээмжтэй байдал, эдийн засаг, зах зээл, бизнесийн ерөнхий нөхцөл байдал гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан тэдгээр ирээдүйд чиглэсэн мэдэгдлээс материаллаг байдлаар ялгаатай байж болно. Дээр тодорхойлсон эрсдэлийн хүчин зүйлс нь Корпорацид нөлөөлөхүйц бүхий л хүчин зүйлсийг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй. Нэмэлт хүчин зүйлсийг Корпорацийн www.sedarplus.ca-д тавигдсан Корпорацийн жилийн мэдээ, тайлангийн “Эрсдэлийн хүчин зүйлс” хэсэгт тэмдэглэсэн болно.

Дээр дурдсан эрсдэлийн хүчин зүйлс нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болох бүх хүчин зүйлс биш бөгөөд бодит үр дүн, нөхцөл байдал нь урьдчилан таамагласан, тооцоолсон эсвэл төлөвлөснөөс өөр байдлыг үүсгэх бусад хүчин зүйлс байж болзошгүй. Урьдчилан таамаглал нь энэхүү УХДШ гарах огноонд тулгуурлан хийгдсэн бөгөөд компани холбогдох хууль тогтоомжоор шаардсан тохиолдлоос бусад нөхцөлд шинэ мэдээлэл, ирээдүйн үйл явдал эсвэл үр дүн зэргээс үл хамааран ийм мэдэгдлийг шинэчлэх, засварлах ямар нэгэн үүрэг хүлээхгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Канад Улсын үнэт цаасны хуулиар тодорхойлогдох энэхүү УХДШ-д тусгасан санхүүгийн аливаа хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг компанийн удирдлага тус УХДШ гарах өдрөөр баталсан болно. Ирээдүйтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хүлээж буй болон төлөвлөж буй ажлын талаар мэдээлэх зорилгоор санхүүгийн хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг өгч байгаа юм. Ийм хэтийн төлөв, ирээдүйн мэдээллүүдийг энэхүү УХДШ-д тусгаснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Компанийн танилцуулга

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсын хязгаарлагдмал хайгуул хийгдсэн өндөр хэтийн төлөв бүхий бүсэд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй уул уурхайн компани юм. Компани нь Торонтогийн хөрөнгийн бирж (TSX:ERD), OTC зах зээл (OTCQX:ERDCF) болон Монголын хөрөнгийн биржид (MSE:ERDN) давхар бүртгэлтэй.

Компани нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 1 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувийг эзэмшдэг бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлүүд дээр хийсэн 20 жилийн судалгааны үр дүнд олборлолтыг эхлүүлсэн Баянхөндий алтны уурхай ("БХ")-г багтаасан Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Хоёр ашиглалтын тусгай зөвшөөрөл болон хайгуулын тусгай зөвшөөрлийг компанийн 50%-ийг нь эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК-иар дамжуулан эзэмшдэг. Зуун Мод зэс-молибденийн төслийг агуулдаг ашиглалтын тусгай зөвшөөрлийг компани 100% эзэмшдэг.

Баруун хойд зүг рүү 50*100 км талбайг хамран оршдог Хөндий Эрдсийн Дүүрэг нь Алтан Нар ("АН"), Баянхөндий, Хар Морь ("ХМ") эпитеpmаль алтны ордууд, Улаан, Хар Морь алтны хэтийн төлөв бүхий талбай болон Зуун Мод ("ЗМ") молибден зэсийн порфирийн ордоос гадна Хөвийн Хар ("ХХ") зэсийн нээлт бүхий хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайгаас бүрддэг. Хөндий Эрдсийн Дүүрэг нь Төв Азийн Орогенийн бүс дэх Транс Алтай Террейнд байрладаг.

Эрдэнэ Ресурс нь Хөндий, Алтан Нар болон Улаан тусгай зөвшөөрлүүд, тэдний хязгаараас 5 км радиуст байрлах аливаа шинээр эзэмших тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлох ашигт малтмалын олборлолтод эхний 400,000 унцаас хэтэрсэн үед 5%-ийн NSR авах эрхтэй. Эрдэнэ Ресурс нь дэлхийн дөрөв дэх том зэс олборлогч болох төлөвтэй Оюу Толгой ордын трендийн үргэлжлэлд байрлах Тэрэг Уул тусгай зөвшөөрлийг 80% хүртэл эзэмших эрхийг олж авах гэрээг 2025 оны 7 сард байгуулсан. Компани нь төслийн багцаа тэлэх боломжуудыг идэвхтэй эрэлхийлсээр байна.

Онцлох үйл явдлууд

Баянхөндий алтны уурхай

- 2026 оны 2-р улиралд 11,709 унц алт, 3,317 унц мөнгө олборлон, борлуулсан нь 2026 оны 1-р улирлын олборлолтод харьцуулахад 37%-иар өссөн үзүүлэлт юм.
 - Алтны нэг унцыг нь дунджаар \$4,493 ам.доллар, мөнгийг нэг унцыг нь \$72 ам.долларын дундаж үнээр борлуулж, нийт 53 сая ам.доллар (75 сая кан.доллар)-ын борлуулалтын орлого төвлөрүүлсэн.
 - Борлуулалтын нийт өртөг 24 сая ам.доллар (33 сая кан.доллар) байв.
- Өдөрт дунджаар 1,682 тонн, нийт 153 мянган тонн хүдэр боловсруулав.
 - Улирлын боловсруулах үйлдвэр тэжээх хүдрийн дундаж агуулга 2.4 г/т байсан нь 2026 оны 1-р улирлаас 25%-иар өссөн үзүүлэлт юм.
 - Алт авалт 96%.
- Эрдэнэ Монгол ХХК-ийн алтны төслүүдийн эрдсийн нөөцийн тооцооллыг боловсруулав.
 - Сүүлийн үеийн хайгуулын үр дүнгүүд болон алтны өнөөгийн ханшийн нөлөөлөл, Баянхөндийн олборлолтын хорогдсон нөөцийг тусган Баянхөндий, Хар Морь болон Алтан Нар ордуудын эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчилсэн.
 - Баянхөндий ордын баруун зүгт орших Улаан ордын эрдсийн нөөцийн анхан шатны тооцооллыг боловсруулсан.
- Орон нутгийн хөгжил болон оролцогч талуудын хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.
 - Улирлын эцсийн байдлаар төслийн талбай дээр ажиллаж буй ажилтнуудын 40 гаруй хувь нь Баянхонгор аймгийн иргэд, Эрдэнэ Монголын нийт ажилтнуудын 13% нь эмэгтэйчүүд байна.
 - Шинэжинст сумын олон нийтийн арга хэмжээнд зориулсан нийтийн эзэмшлийн байгууламжуудыг шинэчлэх, өргөтгөх ажилд дэмжлэг үзүүлэв.
 - Төслийн үйлчилгээ болон байгаль орчны хөтөлбөрүүдийн хүрээнд орон нутгийн гэрээт гүйцэтгэгчидтэй хамтран ажиллаж байна.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуул, хөгжүүлэлт

- Зуун Мод төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг боловсруулж, 2-р хагаст эцэслэхээр төлөвлөж байна.
 - Уурхайн төлөвлөлт, маркетинг болон металлургийн туршилтын ажлуудыг гүйцэтгэсэн.
 - 3-р улирлын сүүлээр хэрэгжүүлэх гүний геофизикийн хайгуулын хөтөлбөрийн гэрээг байгуулсан.
- Оюу Толгойгоос өмнө зүгт ойролцоогоор 10 км-т орших Тэрэг Уул төслийн талбайд нийт 2,710 метрийн 11 цооног өрөмдсөн.
 - Вэб (“Web”) талбайд 1.5 км хүдэржсэн структурын дагуу найман гүехэн цооног өрөмдсөн ба аномаль алт огтолсон (0.1 г/т-оос 1 г/т хүртэл алт, 15 г/т хүртэл мөнгөний агуулга бүхий интервал огтолсон).
 - Гүний геофизикийн судалгаагаар нүүрсний үе болон байгалийн зэсийн ул мөр огтолсон.
 - 2026 оны 7 сард 400,000 ам.долларын опционы төлбөр төлж, Тэрэг Уул төслийн эрхийн гэрээний хугацааг сунгасан.

Компанийн тухай

- 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд 9,993 долларын цэвэр орлоготой ажилласан бол 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд 4,122 долларын цэвэр алдагдалтай байв.
 - Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээн зөвшөөрсөн орлого буюу Эрдэнэ Монгол ХХК-ийн орлогын Компанид ногдох хувь нь 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд 11,201 доллар байсан бол 2025 оны мөн үед 2,995 долларын алдагдал бүртгэсэн. Энэхүү өөрчлөлт нь тайлант улиралд Баянхөндий уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотой бөгөөд өмнөх оны мөн үед уурхай нь бүтээн байгуулалтын шатанд байсан.
 - 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хайгуул, үнэлгээний зардал 726 доллар байсан бол 2025 оны мөн үед 514 доллар байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн энэхүү зардал нь 2025 оны 7 сард хийсэн гэрээний дагуу Тэрэг Уул төслийн хайгуулын ажлууд гүйцэтгэсэнтэй холбоотой.
 - 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын компанийн болон захиргааны зардал 1,617 доллар байсан бол 2025 оны мөн үед 1,488 доллар байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гарсан өөрчлөлт нь хөрөнгө оруулагчидтай харилцах болон зохицуулагч байгууллагатай холбоотой зардлууд өссөнтэй холбоотой.
- 2026 оны 6 сарын 30-нд хувьцаагаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр (“NCIB”)-ийг хэрэгжүүлж эхэлсэн.
 - Хөтөлбөрийн хүрээнд эргэлтэд буй энгийн хувьцаанаас 4,900,000 хүртэлх ширхгийг худалдан авч хүчингүй болгох боломжтой ба энэ нь эргэлтэд буй энгийн хувьцааны ойролцоогоор 10%-тай тэнцэнэ.
 - Өнөөг хүртэл нэгж хувьцааг дунджаар \$5.21 долларын үнээр, нийт 94,400 хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгосон.

Стратеги, хэтийн төлөв

Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий ордын олборлолтыг дэмжих болон хайгуул, хөрөнгө оруулалтад тулгуурлан Хөндий Эрдсийн Дүүрэг, Монгол Улсын хэтийн төлөв бүхий бүсүүдэд ордуудыг илрүүлж, хөгжүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Хөндий Эрдсийн Дүүрэг дэх алтны төслүүдийг Эрдэнэ Ресурс нь Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй хамтран, Эрдэнэ Монгол ХХК-аар дамжуулан эзэмшдэг. ММС нь Монголын нүүрсний салбарт баяжуулсан коксжих нүүрс олборлон, экспортлогч, хувийн хэвшлийн хамгийн том төлөөлөл. Тус компанийн хувьцаа Хонконгийн хөрөнгийн биржид (HKEx:975) нээлттэй арилжаалагддаг.

ММС-ийн гол хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын тэргүүлэгч групп компаниудын нэг болох М-Си-Эс Групп юм. М-Си-Эс нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсад инженерчлэл, барилга, эрчим хүч, харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, эрүүл мэнд, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ирсэн бөгөөд нийт 14,000 гаруй ажилтантай, Монгол Улсын хамгийн том татвар төлөгчдийн нэг. Тус группийн охин компаниуд нь Баянхөндий уурхайн

инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ("EPC") гүйцэтгэгчээр болон эрчим хүч хангагчаар оролцон, Эрдэнэ Монголын голлох гэрээт гүйцэтгэгчид болсон.

Баянхөндий орд, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай, Улаан талбайг багтаасан Хөндий-Улаан томоохон хувирлын бүс нь алт агуулсан гидротермаль системийн нэг хэсэг бөгөөд олон сая унцын нөөц бүхий ордуудыг агуулах боломжтойг харуулж байна. Ирээдүйн хайгуулын хөтөлбөрүүд нь энэхүү систем дэх ордуудыг тэлэх болон шинэ алтны хүдэржсэн бүсүүдэд хийх хайгуул дээр төвлөрөхөөс гадна, Баянхөндий ордоос хойд зүгт 16 км-т орших Алтан Нар алтны томоохон системийн хүрээнд хайгуул болон техникийн судалгаанууд гүйцэтгэнэ.

Үүнтэй зэрэгцэн, Эрдэнэ Ресурс нь Ази тивийн хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден-зэсийн ордуудын нэг Зуун Мод төслийн судалгааг гүйцэтгэн, энэ оны 2-р хагаст урьдчилсан эдийн засгийн тооцооллыг боловсруулахаар төлөвлөсөн. Зуун Мод ордоос гадна тусгай зөвшөөрлийн талбайд хэд хэдэн өндөр хэтийн төлөв бүхий зэс, молибденийн талбай оршдог ба үүнд Хөвийн Хар талбай багтаж байна. Хөвийн Хар талбайд гүйцэтгэсэн өрөмдлөгөөр 0.63% зэсийн агуулга, 2.9 г/т мөнгөний дундаж агуулга бүхий 65 метрийн интервал огтолсон. Энэхүү интервалд 1.25% зэс болон 6.1 г/т мөнгөний агуулга бүхий 30 метр багтаж байна. 2026 оны 3-р улиралд хайгуулын өрөмдлөгөөр шалгах талбайг тодорхойлох зорилгоор Quantec Geoscience компани тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь хамарсан геофизикийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2025 оны 7 сард Компани нь Тэрэг Уул зэс-алтны порфирийн илрэл бүхий талбайн 80 хүртэл хувь эзэмших эрхийг авах опцион гэрээнд гарын үсэг зурсан. Төслийн талбай нь Оюу Толгой зэсийн ордын трендийн дагуу баруун урд зүгт 10 орчим км-ийн зайд байрладаг. 2026 оны 2-р улиралд Тэрэг Уул төслийн талбайд хэрэгжүүлсэн анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр алтны Вэб ("Web") талбайг шалгаж, 1.5 км үргэлжлэх хүдэржсэн трендийн дагуу өрөмдсөн арван цооногийн есөд нь аномаль алтны хүдэржилт огтолсон. Түүнчлэн тусгай зөвшөөрлийн талбайн төв хэсэгт тодорхойлсон геофизикийн бүсийг өрөмдлөгөөр шалгахад аномаль зэс, алтны болон нүүрсний хүдэржилт огтолсон.

Эрдэнэ Ресурс нь Хөндий Эрдсийн Дүүргийн хүрээнд хөрөнгө оруулалтын боломжуудыг идэвхтэй судалж байна. Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөв бүхий 20 гаруй талбайг тодорхойлсон. Мөн компани нь өнгөрсөн хугацааны хайгуулын туршлагад тулгуурлан үнэт болон суурь металлын нөөц бүхий боломжит бүс нутгуудыг тодорхойлохоор ажиллана.

Баянхөндий уурхайн үйл ажиллагааны тухай

Эрүүл, аюулгүй ажиллагаа болон байгаль орчин

2026 оны 2-р улирлын эцэст төслийн талбай дээр нийт 565 ажилтан болон гэрээт ажилтнууд ажиллаж байсан ба тайлант хугацаанд нийт 520 мянган хүн-цаг ажилласан. Өнгөрсөн 12 сарын хугацаанд ажлын цаг алдалтад хүргэсэн гэмтлийн давтамжийн үзүүлэлт (LTIFR) нэг сая хүн/цагт 2 байв.

Тайлант хугацаанд байгаль орчинтой холбоотой тайлагнах зөрчил, осол бүртгэгдээгүй. Байгаль орчны менежментийн үйл ажиллагаа нь болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсээр байгаа бөгөөд үүний зэрэгцээ Баянхөндий төслийн талбайн хоёр га талбайд нутгийн унаган ургамлыг ургуулах туршилтыг хэрэгжүүлэх зэрэг байгаль хамгааллын ажлуудыг идэвхтэй хэрэгжүүлж байна.

Олборлолт болон боловсруулалт

2-р улиралд Эрдэнэ Монгол ХХК нь 3.8 сая тонн материал шилжүүлсэн бөгөөд 1.4 г/т алтны дундаж агуулга бүхий 247 мянган тонн хүдэр олборлосон. 2026 оны 6 сарын 30-ны байдлаар уурхайн техник тоног төхөөрөмжид 18 өөрөө буулгагч машин, 5 экскаватор, 3 бульдозер болон бусад туслах, нөөц тоног төхөөрөмжүүд багтаж байна.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон улиралд Баянхөндийн боловсруулах үйлдвэр нь хоногт дунджаар 1,682 тонн хүдэр буюу нийт 153 мянган тонн хүдэр боловсруулсан. Тайлант улиралд боловсруулсан хүдрийн дундаж алтны агуулга 2.4 г/т байсан нь өмнөх улирлаас 25%-иар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд хүдрийн хяналт болон уурхайгаас үйлдвэр хүртэлх (mine-to-mill) үйл ажиллагаа сайжирч, хүдрийн бохирдол болон алдагдал буурсан нь голлон нөлөөлсөн. 2-р улиралд алт авалт 96%-иас дээш байсан нь төлөвлөсөн 93%-иас давсан үзүүлэлт юм.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон улиралд ЭМ нь 11,709 унц алт, 3,317 унц мөнгө борлуулсан. Алтны нэг унцыг нь дунджаар \$4,493 ам.доллар, мөнгийг нэг унцыг нь \$72 ам.долларын дундаж үнээр борлуулж, нийт 53 сая ам.доллар (75 сая кан.доллар)-ын борлуулалтын орлого төвлөрүүлсэн. Борлуулалтын нийт өртөг 24 сая ам.доллар (33 сая кан.доллар) байв.

Хайгуул

2026 оны хайгуулын хөтөлбөрүүд нь Хөндий Эрдсийн Дүүрэгт Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшдэг Баянхөндий (Баянхөндий болон Хар Морь ордууд), Алтан Нар болон Улаан гэсэн гурван алтны төслийн эрдсийн нөөцийн тооцооллыг ("MRE") шинэчлэхэд чиглэсэн. Эдгээр төслийн шинэчилсэн эрдсийн нөөцийн тооцооллын мэдээллийг энэхүү тайлангийн хавсралт хэсэгт танилцуулсан. Тооцооллыг SLR Advisory Asia Limited ("SLR") 2026 он хүртэлх хайгуулын өрөмдлөгийн бүх мэдээлэл болон Баянхөндий ордын олборлолтоор хорогдсон нөөцийг тусган боловсруулсан.

Үүнээс гадна, металлургийн туршилтад зориулан дээж цуглуулж, Канад Улсын Бритиш Колумби муж дахь Blue Coast Research Limited ("Blue Coast") компанид хүргүүлсэн. Алтан Нар төслийн металлургийн дээжүүдэд шинж чанар тодорхойлох, минералогийн болон цианидын туршилт зэрэг технологийн туршилтуудыг гүйцэтгэсэн. Цианидын туршилтын үр дүн өмнөх судалгааны үр дүнтэй нийцтэй буюу алтны металл авалт 89%, мөнгөний металл авалт 55%-тай байв. Минералогийн шинжилгээгээр цайр агуулсан цор ганц эрдэс нь сфалерит, хар тугалга агуулсан цор ганц эрдэс нь галенит болохыг тогтоосон. Сфалерит болон галенит нь бусад эрдсээс чөлөөлөгдөх байдал сайн бөгөөд арсенопириттай холбоогүй байсан нь уг дээжээс хар тугалга, цайр болон сульфидын (пирит/арсенопирит/алт) нийлмэл баяжмалуудыг тус тусад нь боловсруулах боломжтой болохыг харуулж байна.

Мөн Хар Морь ордоос бага агуулга бүхий багц хүдрийн дээжүүдийг сонгон авч, нуруулдан уусгах технологид тохирох эсэхийг тодорхойлохоор туршилтад хамруулсан бөгөөд үүнд нарийвчилсан баганан уусгалтын туршилт багтсан. Урьдчилсан үр дүн зэрэг байгаа бөгөөд туршилтын нийт үр дүнг 2026 оны 3-р улиралд хүлээн авахаар төлөвлөж байна.

Хүний нөөц

2026 оны 6 сарын 30-ны байдлаар төслийн талбайд компанийн үндсэн болон туслан гүйцэтгэгч байгууллагуудын 565 ажилтан ажиллаж байсан. Эрдэнэ Монгол ХХК-ийн төслийн талбайд ажиллаж байгаа нийт ажилтнуудын 40% нь Баянхонгор аймгийн иргэд байна. Мөн төслийн үндсэн ажилтнуудын 13% нь эмэгтэйчүүд байна.

Орон нутгийн төсөл хөтөлбөрүүд

Компани нь Монголиан Майнинг Корпорэйшн-тэй хамтран Баянхонгор аймгийн иргэдийг уул уурхайн тоног төхөөрөмжийн операторын сургалтад хамруулсан. Улирлын эцэст 180 гаруй иргэд сургалтад хамруулсан ба суралцагчдын дийлэнх нь Баянхөндий уурхайд шилжин ажиллаж байна.

Эрдэнэ Монгол нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлтэй хамтран ажиллаж, орон нутгийн худалдан авалтыг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах, орон нутгийн оюутан залуусын боловсролыг дэмжих зэрэг төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрх ажлуудын хүрээнд Компани 2026 онд Шинэжинст суманд зохион байгуулагдах тэмдэглэлт арга хэмжээнүүдийн үеэр олон нийт ашиглах цэцэрлэгт хүрээлэнг шинэчлэх, өргөжүүлэх ажилд дэмжлэг үзүүлсэн.

Санхүүгийн үр дүн

Дараах хүснэгтэд өмчийн аргаар бүртгэх зорилгоор Компанийн хийсэн бодит үнэ цэнийн тохируулгыг тусган, ЭМ-ын нэгтгэсэн санхүүгийн мэдээллийг 100%-ийн сууриар, канад доллараар хураангуйлан үзүүлэв.

	6 сарын 30 2026	12 сарын 31 2025
хугацаанд		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	\$ 55,953	\$ 18,325
Бусад эргэлтийн хөрөнгө	29,007	23,193
Эргэлтийн бус хөрөнгө	266,068	252,129
Богино хугацаат өр төлбөр	(32,659)	(90,949)
Урт хугацаат өр төлбөр	(184,417)	(108,848)
Цэвэр хөрөнгө	\$ 133,952	\$ 93,850
дуусгавар болсон хугацаанд		
Орлого	\$ 130,378	\$ -
Борлуулалтын өртөг	(63,215)	-
Нийт ашиг	67,163	-
Цэвэр ашиг	\$ 36,328	\$ (10,160)
Бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал)	-	-
Нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)	\$ 36,328	\$ (10,160)

Хөндий Эрдсийн Дүүргийн Нөөцийн Тооцоолол

Дараах хүснэгтэд SLR-ийн боловсруулсан шинэчилсэн тооцооллыг тусган, 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөр хүчин төгөлдөр болсон Хөндий Эрдсийн Дүүрэг дэх Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшлийн төслүүдийн эрдсийн нөөцийн нэгтгэсэн тооцооллыг хураангуйлан үзүүлэв. Төсөл тус бүрийн эрдсийн нөөцийн тооцооллын дэлгэрэнгүй мэдээллийг доорх хэсгүүд болон тайлан дахь хавсралтуудаас үзнэ үү.

Нөөцийн ангилал	Орд	Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан металл	
			Au г/т	Ag г/т	Au мян.унц	Ag мян.унц
Баттай	БХ	2,991	2.13	1.1	204	108
Баттай (нийт)		2,991	2.13	1.1	204	108
Бодитой	БХ	4,816	1.66	1.2	257	182
Бодитой	ХМ	1,407	1.78	1.7	80	75
Бодитой	АН	6,865	1.52	11.7	336	2,583
Бодитой	Улаан	2,262	1.30	0.9	94	68
Бодитой (нийт)		15,350	1.56	5.9	768	2,908
Баттай + Бодитой		18,341	1.65	5.1	972	3,016
Боломжтой	БХ	395	0.91	1.0	11	13
Боломжтой	ХМ	608	0.77	1.4	15	28
Боломжтой	АН	8,083	0.95	5.2	246	1,340
Боломжтой	Улаан	1,539	1.10	0.6	54	28
Боломжтой (нийт)		10,625	0.96	4.1	327	1,408

Гурван төслийн эрдсийн нөөцийн тооцоололд дундаж агуулга харьцангуй өндөр бүсүүд багтсан бөгөөд алтны захын агуулгыг 0.7 г/т-оор тооцсон байдлаар харуулав:

Нөөцийн ангилал	Орд	Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан металл	
			Au г/т	Ag г/т	Au Koz	Ag Koz
Баттай	БХ	1,208	4.49	2.0	174	76
Баттай (нийт)		1,208	4.49	2.0	174	76
Бодитой	БХ	1,416	4.46	2.0	203	101
Бодитой	ХМ	430	4.83	2.4	67	33
Бодитой	АН	4,508	2.16	15.7	313	2,275
Бодитой	Улаан	1,286	1.88	1.2	78	50
Бодитой (нийт)		7,640	2.69	10.0	661	2,459
Баттай + Бодитой		8,848	2.94	9.0	835	2,535
Боломжтой	БХ	151	1.56	1.6	8	8
Боломжтой	ХМ	174	1.68	1.5	9	8
Боломжтой	АН	4,559	1.44	6.8	210	1,000
Боломжтой	Улаан	607	1.95	0.9	38	18
Боломжтой (нийт)		5,492	1.50	5.9	265	1,034


Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд

NI 43-101 Техникийн тайлангууд– Геологийн ба үйлдвэрлэлийн нөөц

2018 оны 9 сарын 15-нд Компани нь Баянхөндий, Алтан Нар алтны төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг танилцуулсан. Түүнээс хойш компани нь NI 43-101 ("NI 43-101")-д заасан "Ашигт малтмалын төслийн ил тод байдлын стандарт"-д заасан стандартын дагуу Баянхөндий Алтны төслийн техникийн тайланг бэлтгэсэн. 2023 оны 8 сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон тайланг "Баянхөндий алтны төсөл, шинэчилсэн ТЭЗҮ, NI 43-101 техникийн тайлан" нэртэйгээр 2023 оны 9 сарын 25-нд танилцуулсан. 2026 оны 9 сард Алтан Нар төслийн шинэчилсэн эрдсийн нөөцийн тооцооллыг багтаасан NI 43-101 стандартын дагуу боловсруулсан шинэчилсэн Техникийн тайланг SEDAR+-т нийтэлнэ. Мөн энэхүү тайланд танилцуулсан Зүүн Өмнөд Улаан (Ulaan SE) алтны ордын эрдсийн анхан шатны нөөцийн тооцооллыг багтаасан Улаан төслийн NI 43-101 стандартын Техникийн тайланг мөн SEDAR+-т нийтэлнэ.

Алтан Нар, Хар Морь, Улаан болон Зуун Модын ордоос бусад Компанийн эзэмшлийн хайгуулын талбай нь хайгуулын эхний шатанд явж буй бөгөөд NI 43-101 тайлагналын стандартын дагуу тайлагнах нөөцийн тайланг боловсруулаагүй. Дээр дурдсан ордуудаас гадна энэхүү Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээнд дурдсан талбайн боломжит агуулга болон хэмжээ нь урьдчилан таамагласан таамаглал бөгөөд нөөцийн тайланг боловсруулах хэмжээний хайгуулын судалгаа хийгдээгүй болно. Компанийн төслүүдийн тухай нэмэлт мэдээллийг www.sedarplus.ca, SEDAR+ дахь компанийн хуудаснаас NI 43-101 техникийн тайлан, жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлүүдээс ("AIF") авч танилцах боломжтой.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуул



Хөндий Эрдсийн Дүүрэг нь Эрдэнэ Монголын газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий Баянхөндий, Хар Морь ба Алтан Нар орд, Зүүн Өмнөд Улаан, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай болон Эрдэнэ Ресурсийн Зуун Мод молибден-зэсийн ордоос бүрддэг. Эрдэнэ Ресурс нь сүүлийн хорь гаруй жилийн турш Монгол Улсын баруун өмнөд хэсэгт төвлөрч, хайгуул судалгааны ажлууд гүйцэтгэж ирсэн ба өндөр агуулга бүхий алт, суурь металлын хэтийн төлөв бүхий талбайнуудаас бүрдсэн Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Баянхөндий ордоос гадна Компани нь Хөндий–Улаан суналын дагуу томоохон хэмжээний алт-зэсийн орд агуулах боломжтой хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон.

Бүс нутгийн өрөмдлөгийн хөтөлбөрийн дундаж гүнийг 100 метр орчим гүехэн өрөмдлөгөөр хязгаарласан бөгөөд цооногуудын 70 орчим хувь нь аномаль алтны хүдэржилт (>0.1 г/т алт) огтолсон. Өмнө нь орчин үеийн хайгуул хийгээгүй бүс нутагт газрын дөт гүнд геохими, геофизикийн хэтийн төлөв бүхий талбайнуудыг тодорхойлсон нь амжилтад хүрэх хүчин зүйл байв. Хайгуулын үр дүнгүүдээр газрын гадаргад ойр гурван ордыг тодорхойлсон нь энэхүү шинэ эрдсийн дүүрэгт нээлт хийх боломж өндөр байгааг харуулж байна.

Баянхөндий ордын эрдсийн нөөцийн тооцоолол

2026 оны эхний хагаст Эрдэнэ Монгол нь Баянхөндий (“ВК”) алтны ордын эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчлэн боловсруулахаар SLR компанитай гэрээ байгуулсан. Доорх хүснэгт-д Канадын Уул уурхай, Металлурги, Газрын тосны хүрээлэн (“СІМ”)-гийн удирдамж болон Уул уурхайн төслийн мэдээллийг ил тод тайлагнах 43-101 (“NI 43-101”)-ийн шаардлагын дагуу SLR Advisory Asia Limited (“SLR”)-ийн боловсруулсан Баянхөндий алтны ордын шинэчилсэн эрдсийн нөөцийн тооцоолол (“MRE”)-ыг хураангуйлан үзүүлэв.

SLR нь 2026 оны 7 сарын 1-ний өдөр хүртэл Эрдэнэ Ресурсийн цуглуулсан мэдээлэлд үндэслэн Баянхөндий ордын эрдсийн нөөцийн тооцооллыг боловсруулсан. Энэхүү мэдээлэлд: нийт 57,395 тууш метрийн 381 алмазан өрөмдлөгийн цооногийн мэдээлэл багтсан бөгөөд үүнээс 32,374 метр нь Эрдэнэ Монгол ХХК-ийн 2015–2024 оны хооронд өрөмдөж, сорьцын шинжилгээ хийлгэсэн мэдээлэл байв. Баянхөндий ордын эрдсийн нөөцийн тооцоолол болон үндэслэсэн мэдээлэл нь NI 43-101-ийн хүрээнд мөрдөгддөг СІМ-ийн Нөөцийн тодорхойлолтын стандартын удирдамжид нийцсэн тул SLR уг тооцооллыг олон нийтэд тайлагнахад тохиромжтой гэж үзсэн. Эрдсийн нөөцийн тооцооллыг SLR-ийн үндсэн ажилтан, Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн бөгөөд NI 43-101-д тодорхойлсон Мэргэшсэн Мэргэжилтэн (“QP”) болох Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан.

Тайлагнасан Баянхөндий ордын эрдсийн нөөцийг ашиглалтын тусгай зөвшөөрлийн (MV-021444) заагаар хязгаарлаж, 2026 оны 7 сарын 1-ний өдрийн байдлаар олборлолтоор хорогдуулсан топографийн гадарга, Юрийн галавын хучаас хурдасны гадарга болон суурь чулуулгийн гранит интрузивийн хил заагийг тусган, захын агуулгыг алтны 0.27 г/т агуулгаас дээш хэмжээнд тайлагнасан. Эрдсийн нөөцийг тооцоолохдоо Баянхөндий ордын нүүрсэнд уусгах технологи бүхий үйлдвэрийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдэд голлон үндэслэсэн ба тооцооны параметрууд болон алт, мөнгөний ханшийг унц тус бүрийг 3,900 ам.доллар, 40 ам.доллар гэж тооцон, ил уурхайн оновчилсон хүрээ (pit shell)-гээр хязгаарлан тайлагнасан. Дэлгэрэнгүй мэдээллийг “Баянхөндий ордын эрдсийн нөөцийн тооцооллын тодруулга тайлбар”-аас үзнэ үү. Дараах эрдсийн нөөцийн тооцоолол нь 2026 оны 7 сарын 1-ний өдрийн байдлаар олборлолтыг хорогдуулан тооцсон эрдсийн нөөц болно.

Баянхөндий ордын эрдсийн нөөцийн тооцоолол, 2026 оны 7 сарын 1-ний өдрийн байдлаар олборлолтын хорогдлыг тусгасан

Нөөцийн ангилал	Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан металл	
		Au г/т	Ag г/т	Au мян.унц	Ag Мян.унц
Баттай	2,991	2.13	1.1	204	108
Бодитой	4,816	1.66	1.2	257	182
Баттай + Бодитой	7,807	1.84	1.2	462	290
Боломжтой	395	0.91	1.0	11	13

Тодруулга:

- (1) Эрдсийн нөөцийн тооцооллын мэдэгдлийг SLR-ийн үндсэн ажилтан бөгөөд Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан. Б.Оюунбат нь тухайн хүдэржилтийн хэв шинж, ордын төрөл болон гүйцэтгэсэн ажлын чиглэлээр хангалттай туршлагатай бөгөөд JORC код-д тодорхойлсон Мэргэшсэн мэргэжилтэн (Competent Person)-ий шаардлагыг хангасан.
- (2) Эрдсийн нөөцийг боловсруулахдаа алтны ханшийг нэг унц тутамд 3,900 ам.доллар, мөнгөний ханшийг нэг унц тутамд 40 ам.доллар байхаар тооцоолсон.
- (3) Эрдсийн нөөцийг 2026 оны 7 сарын 1-ний өдрийн байдлаар топографийн гадаргад үндэслэн олборлолтын хорогдлыг тусгасан.
- (4) Эрдсийн нөөцийг боловсруулахдаа захын агуулгыг 0.27 г/т-оор тайлагнаж, урьдчилсан байдлаар 45°-ын налуу өнцөг бүхий оновчилсон ил уурхайн хүрээгээр хязгаарласан.
- (5) Захын агуулгыг ил уурхайн олборлолтын аргыг ашиглана гэж үзэн, хүдрийн алдагдлыг 2.5%, бохирдлыг 10%, алтны ханш 3,900 ам.доллар/унц, ил уурхайн олборлолтын зардлыг 2.76 ам.доллар/тонн, хүдэр боловсруулах зардлыг 25.56 ам.доллар/тонн, ерөнхий болон захиргааны зардлыг 1.50 ам.доллар/тонн, бүх төрлийн хүдэржилтийн алт авалтыг 93% байхаар тооцож тодорхойлсон. Судалгааны түвшинд оновчилсон ил уурхайн хүрээг алтны ханш 3,900 ам.доллар/унц, мөнгөний ханш 40 ам.доллар/унц, СІР боловсруулалтын алт авалтыг 93%, мөнгө авалтыг 55% байхаар тооцон боловсруулсан.
- (6) Геологийн нөөц (Mineral Resources)-ийн ангилалд багтсан боловч Үйлдвэрлэлийн нөөц (Mineral Reserves)-д шилжээгүй хэсгийн эдийн засгийн үр ашигтай байдал нь нотлогдоогүй болно.
- (7) Тоон үзүүлэлтүүдийг тоймлосон тул нийлбэр дүн нь зөрүүтэй байж болно.
- (8) Эрдсийн нөөцийг 100%-ийн эзэмшлийн сууриар тайлагнасан.

Баянхөндий орд нь өндөр агуулгатай хэд хэдэн бүсээс бүрддэг онцлогтой. Алтны захын агуулгыг 0.7 г/т гэж тооцсон Баянхөндий ордын эрдсийн нөөцийг дараах хүснэгтэд үзүүлэв:

Баянхөндий ордын эрдсийн нөөцийн тооцоолол, захын агуулга 0.7 г/т, 2026 оны 7 сарын 1-ний өдрийн байдлаар олборлолтын хорогдлыг тусгасан

Нөөцийн ангилал	Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан металл	
		Au г/т	Ag г/т	Au Koz	Ag мян.т
Баттай	1,208	4.49	2.0	174	76
Бодитой	1,416	4.46	2.0	203	101
Баттай + Бодитой	2,625	4.47	2.0	377	177
Боломжтой	151	1.56	1.6	8	8

Хар Морь хэтийн төлөв бүхий талбай

Хар Морь хэтийн төлөв бүхий талбай нь (20 км²) Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хойд зүгт оршдог. Өнөөг хүртэл Хар Морь талбайд босоо гүнд 8-318 метрийн хооронд хэлбэлзэх, нийт 30,503 тууш метрийн 301 цооног өрөмдсөн.

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөр нь Баянхөндий ордоос хойд зүгт 2км-т орших 2021 оны эхээр нээн илрүүлсэн Хар Морин Дэл бүсэд төвлөрсөн. Анхны өрөмдлөгөөр (AAD-58) цооногийн 10 метрээс 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метр агуулсан 6.0 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон. Өрөмдлөгийн үр дүнд Хар Морин Дэл талбайд 1.5 км-ийн хувирлын тренд, алтны хүдэржилтийг тодорхойлсон бөгөөд хойд, өмнө болон гүндээ суналын дагуу нээлттэй.

Хар Морин Дэлийн дөт гүний исэлдсэн бүс нь газрын гадаргаас эхлэн, 195 г/т алтны агуулга бүхий 1 метрээс дээш супергенээр баяжуулсан алтны бүсүүдийг агуулан, хугарлын дагуу хэсэгчлэн гүн исэлдэн 20-60 метрийн босоо гүнд өөр өөр зузаантай оршиж байна. Өндөр агуулга бүхий исэлдсэн биет нь хойд өмнөд суналын дагуу үргэлжилж байгааг тодорхойлсон. Хүдэржилт нь судлын дагуу болон гүндээ нээлттэй ч газрын дөт гүнд ойр хүдэржилтийн хэсэг нь Баянхөндий төслийн нэг хэсэг болох Хар Морин Дэлийн нөөцийг бүрдүүлдэг.

2024 онд Эрдэнэ Монгол нь Хар Морь талбайд 4*3 км бүсэд геологийн ба геохимийн судалгаа хийсэн. Энэ нь Хар Морь өндөр агуулга бүхий суперген алтны орд болон хэд хэдэн эхэн үеийн алтны хэтийн төлөв бүхий талбайг агуулдаг өргөн хүрээтэй хөрсний алтны геохимийн аномалиар тодорхойлогддог. Хайгуулын хөтөлбөр нь гол алт агуулагч шинж чанартай бүс нутаг болох хойд-урагш тренд бүхий Хар Морин Дэл ба зүүн-хойд тренд бүхий Алтан Сумын хагаралтай зэрэгцээ орших структурт төвлөрсөн. Нийт 163 чулуулгийн дээжлэлт хийсэн ба хэд хэдэн өндөр агуулга бүхий алтны хүдэржсэн бүсүүдийг тодорхойлсон. 1.8 км зүүн хойд трендийн дагуу структурын шинж чанар бүхий Алтан Сумын хагарлын хайгуулын үр дүнд 37.7 г/т алтны агуулга бүхий дээж, 50.0 г/т мөнгөний агуулгаас дээш 12 дээж, түүн дотор 100 г/т мөнгөний агуулгаас дээш хоёр дээж багтсан. Мөн аномаль хар тугалга, молибден, сурьмагийн дээжүүдийг огтолсон нь энэхүү бүс нутаг нь дундаас дээш сульфиджилт бүхий орчин байх боломжтойг харуулж байна.

2025 оны сүүлээр гүйцэтгэсэн 5,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр нь дараах зорилготой байв: Баянхөндий уурхайн боловсруулах үйлдвэрийг тэжээх боломжтой Өмнөд Хар Морь ордын өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх боломжийг шалгах; хойд зүгт Алтан Сум структурын дагуу болон Өмнөд Хар Морь ордын зүүн хойд чиглэлд үргэлжлэх хүдэржилтийн хүрээнд овоолгон уусгах технологиор боловсруулах боломжтой бага агуулга бүхий нөөц байгаа эсэхийг шалгахар гүйцэтгэсэн. Өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд Хар Морь хүдэржсэн трендийн дагуу нийт 3,993 тууш метрийн 38 цооног, мөн Алтан Сум талбайд нийт 1,440 тууш метрийн 27 цооног өрөмдсөн. Өмнөд Хар Морь бүсэд өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийг тэлж, газрын дөт гүнд 28.7 г/т алтны агуулга бүхий 3 метр, 9.6 г/т алтны агуулга бүхий 19 метрийн интервалыг огтолсон. Хойд Хар Морь талбайд гүйцэтгэсэн өрөмдлөгөөр Өмнөд Хар Морь нөөцийн талбайгаас хойд зүгт исэлдсэн болон шилжилтийн бүсэд агуулагдах бага агуулга бүхий алтны хүдэржилтийн өргөн бүс оршиж байгааг тогтоосон. 2025 оны өрөмдлөгөөр 1 г/т алтны агуулгаас дээш агуулга бүхий 43 метр хүртэлх зузаантай хэд хэдэн интервал огтолсон. Алтан Сум талбайд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр алт, мөнгөний өндөр агуулга бүхий хэд хэдэн интервал огтолсон ба үүнд: 1.36 г/т алтны агуулга бүхий 16 метр, 66 г/т мөнгөний агуулга бүхий 5 метрийн интервал багтаж байна. Нийт өрөмдсөн 65 цооногийн 89% буюу 58 цооногт алт, мөнгөний аномаль бүс огтолсон.

Мөн Хойд Хар Морь талбайн алтны хүдэржсэн исэлдсэн өрмийн дээжийг металлургийн туршилтад илгээсэн бөгөөд овоолгон уусгах технологид тохиромжтой эсэхийг үнэлж байна. Энэ нь цаашид бага өртөгтэй алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх ирээдүйтэй юм.

Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцоолол

2026 оны 2-р улиралд Эрдэнэ Монгол ХХК нь Хар Морь (“DH”) алтны ордын эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчлэн боловсруулахаар SLR компанитай гэрээ байгуулсан. Шинэчилсэн нөөцийн тооцоололд 2022 оны 10 сарын 1-ний өдрөөр хүчин төгөлдөр байсан өмнөх нөөцийн тооцооллоос хойш өрөмдсөн нийт 6,474 метрийн 83 цооногийн мэдээллийг шинээр тусгасан. Доорх хэсэгт Канадын Уул уурхай, Металлурги, Газрын тосны хүрээлэн (“CIM”)-гийн удирдамж болон Уул уурхайн төслийн мэдээллийг ил тод тайлагнах 43-101 (“NI 43-101”)-ийн шаардлагын дагуу SLR Advisory Asia Limited (“SLR”)-ийн боловсруулсан Хар Морь алтны ордын шинэчилсэн эрдсийн нөөцийн тооцоолол (“MRE”)-ыг хураангуйлан үзүүлэв.

SLR нь 2026 оны 5 сарын 1-ний өдрийн байдлаар өмнө нь цуглуулсан мэдээлэлд үндэслэн Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцооллыг боловсруулсан. Энэхүү мэдээлэлд: Эрдэнэ Монголын 2016–2025 оны хооронд өрөмдсөн, нийт 30,630 метрийн 301 алмазан өрөмдлөгийн цооногийн мэдээлэл багтсан. Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцоолол болон түүнд үндэслэсэн мэдээлэл нь NI 43-101-ийн хүрээнд мөрдөгддөг CIM-ийн Нөөцийн тодорхойлолтын стандартын удирдамжид нийцсэн тул SLR нь уг тооцооллыг олон нийтэд тайлагнахад тохиромжтой гэж үзсэн. Эрдсийн нөөцийн тооцооллыг SLR-ийн үндсэн ажилтан, Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн бөгөөд NI 43-101-д тодорхойлсон Мэргэшсэн Мэргэжилтэн (“QP”) болох Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан.

Эрдсийн нөөцийг газрын гадаргын топографи, хучаас хурдасны гадарга болон алтны ханшийг нэг унц тутам 3,900 ам.доллар, мөнгөний ханшийг нэг унц тутам нь 40 ам.доллар байхаар тооцон боловсруулсан ба урьдчилан оновчилсон ил уурхайн хүрээгээр хязгаарласан. Исэлдсэн болон шилжилтийн хүдэржилтийн захын агуулгыг 0.28 г/т, анхдагч хүдэржилтийн захын агуулгыг 0.85 г/т байхаар тайлагнасан. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй “Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцооллын тодруулга, тайлбар” хэсгээс танилцана уу.

Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцоолол, 2026 оны 5 сарын 1-ний өдрөөр хүчин төгөдөр болсон

Нөөцийн ангилал		Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан металл	
			Au г/т	Ag г/т	Au мян.унц	Ag мян.унц
Бодитой	Исэлдсэн	909	2.12	1.8	62	52
	Шилжилтийн	481	1.07	1.4	17	22
	Анхдагч	17	3.28	2.3	2	1
	Нийт	1,407	1.78	1.7	80	75
Боломжтой	Исэлдсэн	290	0.61	1.6	6	15
	Шилжилтийн	317	0.90	1.3	9	13
	Анхдагч	1	7.29	2.0	0.2	0.1
	Нийт	608	0.77	1.4	15	28

Тодруулга:

- Эрдсийн нөөцийн тооцооллын мэдээдлийг SLR-ийн үндсэн ажилтан бөгөөд Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан. Б.Оюунбат нь тухайн хүдэржилтийн хэв шинж, ордын төрөл болон гүйцэтгэсэн ажлын чиглэлээр хангалттай туршлагатай бөгөөд CIM-ийн Мэдээлэл тайлагнах стандартад тодорхойлсон Мэргэшсэн мэргэжилтэн (Qualified Person)-ий шаардлагыг хангасан.
- Дээрх хүснэгтэд тайлагнасан эрдсийн нөөцийн бүх үзүүлэлт нь 2026 оны 5 сарын 1-ний өдрийн байдлаарх тооцоолол болно. Эрдсийн нөөцийн тооцоолол нь нарийвчилсан, эцсийн тооцоо бус бөгөөд хүдэржилтийн байршил, хэлбэр, үргэлжлэлтэй холбоотой хязгаарлагдмал мэдээллийн тайлбар, мөн тухайн үед бэлэн байсан дээжлэлтийн үр дүнд тулгуурладаг. Тооцооллын тодорхой бус байдлыг зохих түвшинд илэрхийлэхийн тулд дээрх хүснэгтийн тоон үзүүлэлтүүдийг тоймлосон. Иймээс тоймлолтоос үүдэн тооцооллын зарим дүнд зөрүү гарч болно.
- Эрдсийн нөөцийг байгаль дахь хуурай жингийн сууриар (dry in-situ basis) тайлагнасан.
- Эрдсийн нөөцийг исэлдсэн болон шилжилтийн хүдэржилтийн хувьд захын агуулгыг алтны 0.28 г/т, анхдагч хүдэржилтийн хувьд захын агуулгыг алтны 0.85 г/т-оор тайлагнаж, 45°-ын налуугийн өнцөг бүхий судалгааны түвшинд оновчилсон ил уурхайн хүрээгээр хязгаарласан. Захын агуулгын үзүүлэлтүүдийг SLR-ийн дотоод тооцоолуур ашиглан, ил уурхайн олборлолтын арга хэрэглэнэ гэж үзэж тодорхойлсон. Тооцоонд хүдрийн алдагдал 2.5%, бохирдол 10%, алтны ханш 3,900 ам.доллар/унц, ил уурхайн олборлолтын зардал 2.76 ам.доллар/тонн, хүдэр боловсруулах зардал 25.56 ам.доллар/тонн, өрөнхий болон захиргааны зардал 1.50 ам.доллар/тонн байхаар тус тус тооцсон. Алтны металл авалтыг исэлдсэн нөөцийн хувьд 90%, шилжилтийн нөөцийн хувьд 87%, анхдагч нөөцийн хувьд 30% байхаар тооцсон. Судалгааны түвшинд оновчилсон ил уурхайн хүрээг алтны ханш 3,900 ам.доллар/унц, мөнгөний ханш 40 ам.доллар/унц, мөнгөний металл авалтыг 55% байхаар тооцон боловсруулсан.
- Дээр дурдсан эрдсийн нөөцөд эдийн засгийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй тул түүний эдийн засгийн үр ашигтай байдал нь нотлогдоогүй болно.

Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцоололд захын агуулгыг алтны 0.7 г/т-аартодорхойлсон, дундаж агуулга өндөр бүсүүд багтсан бөгөөд тэдгээрийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцоолол, захын агуулга 0.7 г/т алт, 2026 оны 5 сарын 1-ний өдрөөр хүчин төгөлдөр болсон

Нөөцийн ангилал		Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан метал	
			Au г/т	Ag г/т	Au мян.унц	Ag мян.унц
Бодитой	Исэлдсэн	269	6.16	2.7	53	23
	Шилжилтийн	142	2.56	1.8	12	8
	Анхдагч	19	3.02	2.2	2	1
	Нийт	430	4.80	2.4	67	33
Боломжтой	Исэлдсэн	39	1.88	1.6	2	2
	Шилжилтийн	134	1.58	1.4	7	6
	Анхдагч	1	6.12	2.1	0	0
	Нийт	174	1.68	1.5	9	8

Улаан төсөл

2021 оны 6-р сард Компани нь Баянхөндий ордоос баруун тийш ердөө 300 метрт Улаан тусгай зөвшөөрлийн талбайд анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлснээр томоохон алтны шинэ нээлтийг илрүүлсэн. 2022 онд хийсэн нэмэлт өрөмдлөгийн үр дүнг багтаасан одоогийн мэдээллүүд нь Зүүн-Өмнөд Улаан талбайд томоохон алтны илрэл байгааг баталгаажуулж байна. Хэд хэдэн цооногуудад (354 метр хүртэл) алтны хүдэржилт илэрсэн бөгөөд 200*250 метрийн талбайг хамарсан энэхүү өрөмдлөгийн дийлэнх нь хүдэржилтээр төгссөн. Зүүн Өмнөд Улаан талбайд огтолсон алтны хүдэржилт нь газрын гадаргаас ойролцоогоор 80 метрийн гүнээс эхлэх бөгөөд 4 метрийн гүнд аномаль алт (UDH-18) огтолсон нь суналын дагуу баруун, баруун хойд чиглэлд болон гүн рүү нээлттэй байна. 156 г/т хүртэл алтны агуулга нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд орших Баянхөндий эпитермааль алтны ордыг агуулагч структур болон тэжээгч бүсүүдтэй холбоотой кварцгематитын судлууд, штокверк бүсүүдэд тохиолдоно.

2026 оны 2-р улиралд Эрдэнэ Монгол ХХК нь Зүүн Өмнөд Улаан (Ulaan SE) алтны ордын эрдсийн нөөцийн анхан шатны тооцооллыг боловсруулахаар SLR компанитай гэрээ байгуулсан. Зүүн Өмнөд Улаан ордын эрдсийн нөөцийн тооцоололтой холбоотой NI 43-101 стандартын Техникийн тайланг 45 хоногийн дотор SEDAR-т нийтэлнэ.

SLR нь 2026 оны 6 сарын 1-ний өдрийн байдлаар Эрдэнэ Ресурсийн цуглуулсан мэдээлэлд үндэслэн Зүүн Өмнөд Улаан ордын нөөцийн тооцооллыг боловсруулсан. Энэхүү мэдээлэлд: Эрдэнэ Ресурсийн 2022 онд өрөмдсөн, нийт 15,025 метрийн 56 өрөмдлөгийн цооногийн мэдээлэл багтсан. Улаан ордын эрдсийн нөөцийн тооцоолол болон түүнд үндэслэсэн мэдээлэл нь NI 43-101-ийн хүрээнд мөрдөгддөг CIM-ийн Нөөцийн тодорхойлолтын стандартын удирдамжид нийцсэн тул SLR нь уг тооцооллыг олон нийтэд тайлагнахад тохиромжтой гэж үзсэн. Эрдсийн нөөцийн тооцооллыг SLR-ийн үндсэн ажилтан, Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн бөгөөд NI 43-101-д тодорхойлсон Мэргэшсэн Мэргэжилтэн ("QP") болох Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан.

Эрдсийн нөөцийг газрын гадаргын топографи, хучаас хурдасны гадарга болон XV-016057 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн хилээр хязгаарласан. Ил аргаар олборлох эрдсийн нөөцийн захын агуулгыг алтны 0.15 г/т хэмжээнд, алтны ханшийг нэг унц тутамд 3,900 ам.доллар байхаар тооцон, оновчилсон ил уурхайн хүрээнд тайлагнасан. Харин далд аргаар олборлох эрдсийн нөөцийг уг алтны ханшийг нэг унц тутамд 3,900 ам.долларт үндэслэн, оновчилсон ил уурхайн хүрээнээс доош байрлах хүдэржилтийн хувьд захын агуулгыг алтны 0.46 г/т байхаар тайлагнасан. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй "Зүүн Өмнөд Улаан ордын эрдсийн нөөцийн тооцооллын тодруулга, тайлбар" хэсгээс танилцана уу.

Зүүн Өмнөд Улаан эрдсийн нөөцийн тооцоолол, 2026 оны 6 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон

Нөөцийн ангилал	Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан металл	
		Au г/т	Ag г/т	Au мян.унц	Ag мян.унц
Бодитой	2,262	1.30	0.9	94	68
Боломжтой	1,539	1.10	0.6	54	28

Тодруулга:

- (1) Эрдсийн нөөцийг тооцоолохдоо CIM (2014)-ийн тодорхойлолтуудыг мөрдсөн.
- (2) Эрдсийн нөөцийн тооцооллын мэдээдлийг SLR-ийн үндсэн ажилтан бөгөөд Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан. Б.Оюунбат нь тухайн хүдэржилтийн хэв шинж, ордын төрөл болон гүйцэтгэсэн ажлын чиглэлээр хангалттай туршлагатай бөгөөд CIM-ийн Мэдээлэл тайлагнах стандартад тодорхойлсон Мэргэшсэн мэргэжилтэн (Qualified Person)-ий шаардлагыг хангасан.
- (3) Дээрх хүснэгтэд тайлагнасан эрдсийн нөөцийн бүх үзүүлэлт нь 2026 оны 6 сарын 1-ний өдрийн байдлаарх тооцоолол болно. Эрдсийн нөөцийн тооцоолол нь нарийвчилсан тооцоо бус бөгөөд хүдэржилтийн байршил, хэлбэр, үргэлжлэлтэй холбоотой хязгаарлагдмал мэдээллийн тайлбар болон тухайн үед бэлэн байсан дээжлэлтийн үр дүнд тулгуурладаг. Тооцооллын тодорхой бус байдлыг зохих түвшинд илэрхийлэхийн тулд дээрх хүснэгтийн тоон үзүүлэлтүүдийг тоймлосон. Иймээс тоймлолтоос үүдэн тооцооллын зарим дүнд зөрүү гарч болно.
- (4) Эрдсийн нөөцийг байгаль дахь хуурай жингээр (dry in-situ basis) тайлагнасан.
- (5) Эрдсийн нөөцийг тооцоолохдоо алтны урт хугацааны ханшийг нэг унц тутамд 3,900 ам.доллар байхаар тооцсон.
- (6) Ил уурхайн аргаар олборлох эрдсийн нөөцийн захын агуулгыг алтны 0.15 г/т-аар тооцож, 50°-ын налуугийн өнцөг бүхий урьдчилан оновчилсон ил уурхайн хүрээгээр хязгаарласан.
- (7) Далд уурхайн аргаар олборлох эрдсийн нөөцийн эдийн засгийн үндэслэлтэйгээр олборлох боломжийн бодит хэтийн төлөв (RPEEE)-ийг дээрх оновчилсон ил уурхайн хүрээнээс доош байрлах нөөцийн захын агуулгыг алтны 0.46 г/т гэж тайлагнах замаар үндэслэсэн.
- (8) Оновчилсон ил уурхайн хүрээ болон захын агуулгыг тооцоолохдоо ил уурхайн олборлолтын зардлыг 3 ам.доллар/тонн, далд уурхайн олборлолтын зардлыг 35 ам.доллар/тонн, хүдэр боловсруулах зардлыг 16 ам.доллар/тонн, хүдрийн бохирдлыг 10%, хүдрийн алдагдлыг 5%, металл авалтыг 95% байхаар тус тус тооцсон.
- (9) Үйлдвэрлэлийн нөөцөд шилжээгүй геологийн нөөцийн эдийн засгийн үр ашигтай байдал нь нотлогдоогүй болно.

Зүүн Өмнөд Улаан ордын эрдсийн нөөцийн тооцоололд захын агуулгыг 0.7 г/т-аар тодорхойлсон, дундаж агуулга өндөртэй бүсүүд багтсан бөгөөд дараах байдлаар үзүүлэв:

Зүүн Өмнөд Улаан эрдсийн нөөцийн тооцоолол, захын агуулга 0.7 г/т алт, 2026 оны 6 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон

Нөөцийн ангилал	Хэмжээ мян.т	Агуулга		Агуулсан метал	
		Au г/т	Ag г/т	Au Koz	Ag мян.т
Бодитой	1,286	1.88	1.2	78	50
Боломжтой	607	1.95	0.9	38	18

Баянхөндий орд, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай, Зүүн-Өмнөд Улаан талбайд хийсэн өрөмдлөгийн үр дүн нь Улаан талбайгаас зүүн хойд зүгт Хөндий тусгай зөвшөөрөл хүртэл 10 гаруй км үргэлжилдэг 4,000 га талбайг хамрах Хөндий-Улаан гидротермаль системийн хүдэржилтийн цар хүрээг харуулж байна.

Үүнээс гадна Улаан тусгай зөвшөөрлийн төв болон хойд хэсэг нь газрын гадарга дээр 5км х 4км хэмжээтэй филлик хувирлын (кварц-серицит-пирит) өргөн бүс үүсгэсэн порфирийн хэтийн төлөвтэй талбай хэмээн тодорхойлдог. Улаан талбайд гадаргуун чулуун дээжлэлт болон урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийн, алт, зэс болон молибденийн хэд хэдэн хуримтлал бүхий гажил байгааг тогтоосон. Мөн геофизикийн судалгаагаар цаашид гүн рүү судлах өрөмдлөгийн хэд хэдэн талбайг тодорхойлсон.

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх хүсэлт гаргахтай холбоотой хууль тогтоомжид заасан баримт бичгийг 2026 оны 2-р хагас жилд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Алтан Нар

Алтан Нар орд нь Баянхөндий ордоос баруун хойд зүгт 16 км-т орших Эрдэнэ Монгол ХХК-ийн Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн 4,669 га талбайд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 3-р сарын 5-ны өдөр АМГТГ-аас авсан бөгөөд нийт 30 жилийн хугацаатай, цаашид 20 жилээр хоёр удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлийн талбайд 5.6 х 1.5 км хүдэржсэн бүсийн дагуу 18 (алт, мөнгө, хар тугалга, цайр) хэтийн төлөвт хайгуулын талбайг тодорхойлсон. Эдгээрээс

эхний нээлтүүд болох “Нээлтийн бүс” (“НБ”), “Хойд Холбоо” (“ХХ”) бүсүүд нь Эрдэнэ Ресурсийн 2018 оны 2-р улиралд танилцуулсан нөөцийн шинэчилсэн тайлан дахь хамгийн их судлагдсан, газрын дөт гүнд өндөр агуулгатай бүсүүдийг агуулдаг.

Алтан Нар нь карбонат-полиметаллт алтны (“СВМГ”) орд гэж үзэж байгаа ба Карбонат-полиметаллт алтны орд нь эпитеpmаль ордын дэд бүлэгт хамаардаг ба Баррик Гоулдын Поргера уурхай (Папуа Шинэ Гвиней), Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай (Индонези), Лундинын Фрута Дел Норте (Эквадор), Континентал Гоулдын Буритика төсөл (Колумби) зэрэг ордуудтай төстэй геологийн тогтоцтой. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын дээд хэсэгт тохиолдох ба хүдэржилт нь 500 гаруй метр гүн үргэлжлэх боломжтой байдаг.

Өнгөрсөн жилүүдэд Компани нь Баянхөндий төсөлд төвлөрөн ажилласан тул Алтан Нар төслийн талбайд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн. Нээлтийн бүсэд 2019 оны 4-р улиралд нийт 667 тууш метр 5 цооногт өрөмдлөгийн судалгаа хийсэн. Нээлтийн бүсэд урьд нь өрөмдлөг хийж байгаагүй 70 метр талбайд (“Gap Zone”) өндөр агуулга бүхий цөмийг судлахаар 130 метрийн урт дөрвөн цооног өрөмдсөн. Ордыг өмнө зүгт тэлэх боломжтой талбайг тав дахь цооногоор шалгасан. 2019 оны хайгуулын хөтөлбөрийн үр дүнгээр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135) нь өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүнд тооцогдож байна. Дээрх мэдээлэл нь 2026 оны 6 сарын 1-нд боловсруулсан Алтан Нар ордын шинэчилсэн эрдсийн нөөцийн тооцоололд багтсан.

Нээлтийн бүс ба Хойд Холбоо талбайд бодитой нөөц тодорхойлогдсон бол үлдсэн 16 хэтийн төлөв бүхий талбайд Эрдэнэ Монгол ХХК үргэлжлүүлэн хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлж, хүдэржсэн системийн ойлголтыг бататгахаар төлөвлөсөн.

2026 оны 2-р улиралд Эрдэнэ Монгол ХХК нь Алтан Нар ордын эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчлэн боловсруулахаар SLR компанитай гэрээ байгуулсан. Алтан Нар ордын шинэчилсэн эрдсийн нөөцийн тооцооллыг багтаасан NI 43-101 стандартын Техникийн тайланг 45 хоногийн дотор SEDAR+-т нийтэлнэ.

Доорх хүснэгтэд тайлагнасан эрдсийн нөөцийн үзүүлэлт нь 2026 оны 6 сарын 1-ний өдрийн байдлаарх тооцоолол бөгөөд 2022 оны 10 сарын 1-ний өдрийг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн мэдээлэлд үндэслэсэн. Эрдсийн нөөцийн тооцоолол болон түүнд үндэслэсэн мэдээлэл нь NI 43-101-ийн хүрээнд мөрдөгддөг CIM-ийн Нөөцийн тодорхойлолтын стандартын удирдамжид нийцсэн тул SLR уг тооцооллыг олон нийтэд тайлагнахад тохиромжтой гэж үзсэн. Эрдсийн нөөцийн тооцооллыг Мэргэшсэн мэргэжилтэн (Qualified Person) Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан.

Эрдсийн нөөцийн мэдэгдлийг газрын гадаргын топографи болон хучаас хурдасны гадаргаар хязгаарласан. Нэг унц алтны ханшийг 3,900 ам.доллар байхаар тооцсон бөгөөд оновчилсон ил уурхайн хязгаар дахь захын агуулгыг 0.18 г/т эрдсийн нөөцийг алттай дүйцэх нэгж (AuEq)-ээс дээш, харин ил уурхайн хязгаараас доош байрлах нөөцийн захын агуулгыг 0.55 г/т алттай дүйцэх нэгжээс дээш хэмжээнд тус тус тайлагнасан.

Алтан Нар ордын эрдсийн нөөцийн тооцоолол – 2026 оны 6 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон

Нөөцийн ангилал		Хэмжээ	Агуулга					Агуулсан метал				
			Au	Ag	Zn	Pb	AuEq	Au	Ag	Zn	Pb	AuEq
		мян.т	г/т	г/т	%	%	г/т	мян.унц	мян.унц	мян.т	мян.т	мян.унц
Бодитой	Исэлдсэн	704	1.56	10.3	0.5	0.8	1.88	35	234	4	6	43
	Анхдагч	6,161	1.52	11.9	0.5	0.4	1.79	301	2,349	33	26	355
	Нийт	6,865	1.52	11.7	0.5	0.5	1.80	336	2,583	37	32	397
Боломжтой	Исэлдсэн	1,360	1.16	5.8	0.4	0.6	1.37	51	256	6	8	60
	Анхдагч	6,723	0.91	5.0	0.4	0.3	1.08	196	1,084	29	22	233
	Нийт	8,083	0.95	5.2	0.4	0.4	1.13	246	1,340	35	30	293

Тодруулга:

- (1) Эрдсийн нөөцийг тайлагнахдаа CIM-ийн Эрдсийн нөөцийн тодорхойлолтын стандарт (2014)-ыг мөрдсөн.
- (2) Эрдсийн нөөцийн тооцооллын мэдэгдлийг SLR-ийн үндсэн ажилтан бөгөөд Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан. Б.Оюунбат нь тухайн хүдэржилтийн хэв шинж, ордын төрөл болон гүйцэтгэсэн ажлын чиглэлээр хангалттай туршлагатай бөгөөд CIM-ийн Мэдээлэл тайлагнах стандартад тодорхойлсон Мэргэшсэн мэргэжилтэн (Qualified Person)-ий шаардлагыг хангасан.
- (3) Дээрх хүснэгтэд тайлагнасан эрдсийн нөөцийн бүх үзүүлэлт нь 2026 оны 6 сарын 1-ний өдрийн байдлаарх тооцоолол бөгөөд 2022 оны 10 сарын 1-ний өдрийг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн мэдээлэлд үндэслэсэн. Эрдсийн нөөцийн тооцоолол нь нарийвчилсан тооцоо бус бөгөөд хүдэржилтийн байршил, хэлбэр, үргэлжлэлтэй холбоотой

- хязгаарлагдмал мэдээллийн тайлбар болон тухайн үед бэлэн байсан дээжлэлтийн үр дүнд тулгуурладаг. Тооцооллын тодорхой бус байдлыг зохих түвшинд илэрхийлэхийн тулд дээрх хүснэгтийн тоон үзүүлэлтүүдийг тоймлосон. Иймээс тоймлолтоос үүдэн тооцооллын зарим дүнд зөрүү гарч болно.
- (4) Эрдсийн нөөцийг байгаль дахь хуурай жингээр (dry in-situ basis) тайлагнасан.
- (5) Эрдсийн нөөцийг алтны ханшийг нэг унц тутамд 3,900 ам.доллар байхаар тооцон, оновчилсон ил уурхайн хязгаар дахь хүдэржилтийн хувьд захын агуулгыг 0.18 г/т AuEq, харин уг ил уурхайн хязгаараас доош 0.55 г/т AuEq байхаар тайлагнасан. Захын агуулгын үзүүлэлтүүдийг SLR-ийн дотоод тооцоолуур ашиглан тодорхойлсон бөгөөд эдийн засгийн тэнцлийн захын агуулгыг (break-even cut-off grade) ил уурхайн хязгаар дахь хүдэржилтийн хувьд 0.18 г/т AuEq, уг хязгаараас доош байрлах хүдэржилтийн хувьд 0.55 г/т AuEq гэж тооцсон. Тооцоонд алтны ханшийг 3,900 ам.доллар/унц, мөнгөний ханшийг 40 ам.доллар/унц, цайрын ханшийг 3,000 ам.доллар/тонн, хар тугалганы ханшийг 2,000 ам.доллар/тонн, ил уурхайн олборлолтын зардлыг 2.75 ам.доллар/тонн, далд уурхайн олборлолтын зардлыг 35 ам.доллар/тонн, хүдэр боловсруулах зардлыг 16 ам.доллар/тонн байхаар тус тус тооцсон. Металл авалтыг алт (Au) 88.8%, мөнгө (Ag) 80.6%, хар тугалга (Pb) 80.4%, цайр (Zn) 69.1% байхаар тооцсон.
- (6) Алттай дүйцэх нэгжийн (AuEq) алтны ханш 3,900 ам.доллар/унц, мөнгөний ханш 40 ам.доллар/унц, хар тугалганы ханш 2,000 ам.доллар/тонн, цайрын ханш 3,000 ам.доллар/тонн байхаар тооцон тодорхойлсон. Металлургийн авалтыг харгалзан тохируулга хийсэн бөгөөд энэ нь Компанийн урьдчилсан металлургийн туршилтын үр дүнд үндэслэсэн. Туршилтаар флотацийн аргыг ашиглан баяжмалуудыг, үүний дотор пиритийн баяжмалыг тусгаарласан бөгөөд зөвхөн алт, мөнгөний эдийн засгийн өгөөжийг тооцсон. Алт, мөнгө, хар тугалга, цайрын агуулга болон агуулагдах металлын хэмжээнд үндэслэн эдгээр бүх металлыг эдийн засгийн үр ашигтайгаар олборлох боломжийн бодит хэтийн төлөвтэй гэж үзсэн.
- a. Алттай дүйцэх нэгжийг дараах томъёогоор тооцсон: $AuEq (g/t) = Au (g/t) + Ag (g/t) \times 0.0093 + Pb (\%) \times 0.144 + Zn (\%) \times 0.186$. Үүнд металлургийн металл авалтыг Au 88.8%, Ag 80.6%, Pb 80.4%, Zn 69.1% гэж тооцсон.
- b. Алттай дүйцэх унцын хэмжээг эрдсийн нөөцийн тонныг алттай дүйцэх нэгжээр үржүүлж, унцад хөрвүүлэх замаар тооцсон. Дараах томъёог ашигласан: $AuEq (унц) = [Тонн \times AuEq \text{ агуулга } (g/t)] / 31.1035$
- (7) Дээр дурдсан эрдсийн нөөцөд эдийн засгийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй тул түүний эдийн засгийн үр ашигтай байдал нь нотлогдоогүй болно.

Алтан Нар ордын эрдсийн нөөцийн тооцоололд захын агуулгыг 0.7 г/т байхаар тодорхойлсон, дундаж агуулга өндөртэй бүсүүд багтсан бөгөөд тэдгээрийг дараах байдлаар үзүүлэв:

Алтан Нар ордын эрдсийн нөөцийн тооцоолол, захын агуулга 0.7 г/т AuEq, 2026 оны 6 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон

Нөөцийн ангилал			Агуулга					Агуулсан металл				
			Au	Ag	Zn	Pb	AuEq	Au	Ag	Zn	Pb	AuEq
			г/т	г/т	мян.т	г/т	г/т	мян.унц	мян.унц	мян.т	мян.т	мян.унц
Бодитой	Исэлдсэн	422	2.40	15.3	0.6	1.3	2.84	33	207	3	5	39
	Анхдагч	4,086	2.13	15.7	0.6	0.5	2.48	280	2,068	26	21	325
	Нийт	4,508	2.16	15.7	0.6	0.6	2.51	313	2,275	29	27	364
Боломжтой	Исэлдсэн	712	1.93	8.1	0.6	0.9	2.24	44	185	4	6	51
	Анхдагч	3,847	1.34	6.6	0.6	0.4	1.57	166	814	21	17	194
	Нийт	4,559	1.44	6.8	0.6	0.5	1.68	210	1,000	25	23	246

Эрдсийн нөөцийн тооцооллын ажлаас гадна Нээлтийн Бүс ("Discovery Zone")-ээс авсан, хүнцэл (As)-ийн бага агуулгатай нэг нийлмэл дээжид металлургийн нэмэлт туршилт хийсэн. Үүнд: дээжийн шинж чанарын тодорхойлолт, минералогийн шинжилгээ болон цианиджуулалтын туршилт багтсан. Тус дээжийн тэжээлийн агуулгын (head grade) шинжилгээний үр дүн дараах байдалтай байна:

Алтан нар ордын металлургийн дээжийн тэжээлийн агуулгын шинжилгээний дүн

Нийлмэл дээж	Au (г/т)	Ag (г/т)	Pb (%)	Zn (%)	Fe (%)	As (%)
AN-MET-25-01	5.48	32.38	0.87	0.99	5.19	0.20

Нээлтийн бүсийн (DZ) дээжид хийсэн минералогийн шинжилгээгээр пирит, сфалерит болон галенит нь үндсэн сульфидын эрдсүүд болохыг тогтоосон бөгөөд арсенопирит болон халькопиритийн ул мөр илэрсэн. Элементүүдийн эрдсүүд дэх тархалтын шинжилгээгээр цайр агуулсан цорын ганц эрдэс нь сфалерит, хар тугалга агуулсан цорын ганц эрдэс нь галенит болохыг тогтоосон. Сфалерит болон галенит нь бусад эрдсээс чөлөөлөгдсөн байдал сайн бөгөөд арсенопириттай холбоогүй байгаа нь уг дээжээс хар тугалга, цайр болон сульфидын (пирит/арсенопирит/алт) нийлмэл баяжмалуудыг тус тусад нь боловсруулах боломжтойг харуулж байна. Энэхүү боломжийг илүү нарийвчлан үнэлэхийн тулд флотацийн нэмэлт туршилт хийх шаардлагатай.

Цианиджуулалтын туршилтын үр дүнгээр хүдрийн цианиджуулалтын дундаж металл авалт алтны хувьд 89%, мөнгөний хувьд 55% байв. Туршилтад хамруулахдаа 67-92 микрон хүртэл нунтагласан нь металл авалтад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болохыг тогтоосон. Дээрх үр дүн нь ижил төстэй дээжүүдэд өмнө нь тогтоогдсон алт, мөнгөний металл авалтын түвшинтэй нийцэж байна.

Зуун Мод молибден-зэсийн төсөл

Зуун Мод молибден-зэсийн төсөл нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт, Компанийн эзэмшлийн Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд орших порфирын төрлийн молибден-зэсийн орд юм. Тус төсөл нь Улаанбаатар хотоос баруун урд зүгт ойролцоогоор 950 км, Монгол-БНХАУ-ын хил дээрх Сэхээ боомтын төмөр замын зангилаанаас 215 км, Баянхөндий ордоос зүүн тийш 35 км зайд байрладаг. Төсөл нь нийт 6,041 га талбайг хамарсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Компанийн охин компани Аниан Ресорсиз ХХК-ийн эзэмшилд байдаг. Энэ төслийг Галлант Минералз Лимитэд компаниас 2005 онд авсан бөгөөд Версамет Роялтис ("Versamet Royalties") компанид буцаан худалдаж авах боломжтой 1.5%-ийн NSR роялти төлөх үүрэг хүлээсэн.

2025 оны 10-р сард Эрдэнэ Ресурс нь Зуун Мод молибден-зэсийн ордын 0.035% молибденийн захын агуулгаар шинэчилсэн нөөцийн тооцооллыг танилцуулсан.

Нөөцийн ангилал	Тонн Сая.т	Мо %	Си %	МоEq %	Мо сая.ф	Си сая.ф	МоEq сая.ф
Баттай	45.8	0.057	0.062	0.074	57.7	62.2	74.8
Бодитой	225.3	0.056	0.065	0.073	275.9	322.0	364.4
Баттай+Бодитой	271.1	0.056	0.064	0.073	333.5	384.2	439.2
Боломжтой	269.1	0.051	0.059	0.070	300.0	350.7	416.3

Тодруулга, 2025 оны 9 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон Зуун Мод төслийн нөөцийн тооцоолол:

- Эрдсийн нөөцийг тайлагнахдаа CIM-ийн Эрдсийн нөөцийн тодорхойлолтын стандарт (2014)-ыг мөрдсөн.
- Эрдсийн нөөцийн тооцооллын мэдэгдлийг SLR-ийн үндсэн ажилтан бөгөөд Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн Бат-Очир овогтой Оюунбат боловсруулсан. Б.Оюунбат нь тухайн хүдэржилтийн хэв шинж, ордын төрөл болон гүйцэтгэсэн ажлын чиглэлээр хангалттай туршлагатай бөгөөд CIM-ийн Мэдээлэл тайлагнах стандартад тодорхойлсон Мэргэшсэн мэргэжилтэн (Qualified Person)-ий шаардлагыг хангасан.
- Дээрх хүснэгтэд дурдсан ашигт малтмалын нөөцийн мэдээлэл нь 2025 оны 9 сарын 1-ний байдлаарх тооцоолол юм. Ашигт малтмалын нөөцийн тооцоолол нь ордын байршил, хэлбэр, үргэлжлэлийн мэдээлэл болон дээжлэлтийн үр дүнд тулгуурласан таамаг тооцоолол. Тооцооллоос үүдэн дээрх хүснэгтэд буй нийлбэрийг бүхэлдсэн бөгөөд үүнээс үүдэн зарим тохиолдолд тооцооллын зөрүү гарах магадлалтай.
- Ашигт малтмалын нөөцийг байгаль дахь, хуурай нөхцөлөөр тайлагнасан.
- Ашигт малтмалын нөөцийг MV-016836 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хилээр хязгаарлаж, молибденийн (Мо) захын агуулга 0.035%-аас дээш, Мо-гийн ханшийг US\$22/фунт, Си-гийн ханшийг US\$4.95/фунтээр тооцсон ба орлогын хүчин зүйлийн дагуу оновчлогдсон уурхайн хүрээнд тайлагнасан. Захын агуулгын параметруудийг SLR нь өөрийн дотоод тооцоолуур ашиглан сонгосон бөгөөд ил уурхайн аргаар олборлох, 3% хүдэр алдагдал, 4% хорогдол бүхий, Мо-гийн ханш US\$15.4/фунт, ил уурхайн зардал US\$2.18/тонн, боловсруулах зардал US\$6.85/тонн, металл авалт Мо-д 83%, Си-д 81% гэж үзсэн. Молибден, зэсийн баяжмалыг флотацийн аргаар боловсруулах технологид үндэслэсэн. Оновчлол бүхий уурхайн хүрээг Мо-ийн ханш US\$22/фунт, Си-ийн ханш US\$4.95/фунтээр тооцоолж тогтоосон.
- Мо-ийн эквивалент (МоEq)-ийг дараах томъёогоор тооцсон: $МоEq\% = Мо\% + Си\% \times 0.27504$, металл авалтыг Мо-83%, Си-81% гэж үзсэн.
- 1 тонн = 2204.64 фунт.
- Дээр дурдсан Ашигт малтмалын нөөцийн хүрээнд дэлгэрэнгүй эдийн засгийн тооцооллыг боловсруулаагүй тул бодит эдийн засгийн өгөөжийг тодорхойлоогүй.

2025 оны сүүлээр Компани өөрийн 100% эзэмшлийн Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд нийт 3,362 тууш метрийн 24 цооног өрөмдсөн. Хөтөлбөрийн хүрээнд: Зуун Мод ордын газрын гадаргаас эхлэн 150 метрийн гүн хүртэлх хүдэржилтийг шалгах 18 цооног, Хойд Рэйстрак бүсэд молибденийн хүдэржилт гүндээ үргэлжилж буй эсэхийг тодорхойлохоор нэг цооногийг (ZMD-98) гүн рүү тэлж өрөмдсөн. ZMD-98 цооногийн өргөтгөлөөс бусад бүх цооногийг -45°-аас -60° хүртэлх налуу өнцгөөр өрөмдсөн. Мөн зэсийн порфирийн бүсүүдийг шалгах зорилгоор 2 цооног (ZMD-162 ба 163) Зуун Мод ордоос баруун зүгт 3.8 км-т орших алтны хэтийн төлөв бүхий бүсийг шалгахгаар гурван хайгуулын цооног өрөмдсөн. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг шинэчилсэн нөөцийн тооцоололд тусган, 2026 оны 3-р улиралд танилцуулахаар төлөвлөж буй Анхан шатны эдийн засгийн тооцооллын суурь болгон ашиглана. Мөн Урьдчилсан эдийн засгийн тооцоолол (PEA)-д ашиглах боловсруулах технологийн урсгал схем (conceptual process flow sheet)-ийг боловсруулах зорилгоор Зуун Мод ордын хүдрийн агуулгыг төлөөлөх цуврал дээжийг металлургийн туршилт хийлгэхээр Blue Coast Research компанид хүргүүлсэн.

Газрын гадаргад ойр гүйцэтгэсэн өрөмдлөгөөр босоо чиглэлд 130 метр хүртэл гүнд өндөр агуулга бүхий молибден, зэсийн хүдэржилтийг огтолсон. Хэд хэдэн цооногт 112 метр хүртэлх гүнд 0.07% молибденийн эквивалент ("МоEq") агуулга бүхий интервал огтолсон ба зарим цооног нь хүдэржилтээр төгссөн. Энэ нь хүдэржилт босоо болон дэд хэвтээ чиглэлд үргэлжилж буйг баталж, өмнө нь бага агуулгатай эсвэл хүдэржилтгүй хэмээн загварчилсан бүсүүдийг нөхөн тодорхойлсноор шинэчилсэн нөөцийн загварыг баталгаажууллаа.

Ордын хойд хэсэгт, харьцангуй бага судалгаа хийсэн талбайд өрөмдсөн ZMD-98 өргөтгөлийн цооног нь дийлэнх хэсэгт молибден, зэсийн хүдэржилт огтолж, 450 метрийн гүнд хүдэржилтээр төгссөн. Өмнө мэдээлсэн үр дүнтэй нэгтгэн үзвэл, энэхүү цооног нь Хойд Рэйстрак бүсийн төв хэсэгт 0.066% молибденийн эквивалент агуулга бүхий 374 метрийн (76-аас 450 метр) интервал огтолсон. Энэхүү өндөр агуулгатай бүс нь босоо болон хажуу чиглэлд нээлттэй байгаа тул цаашдын өрөмдлөгийг голлон энэ бүсэд чиглүүлэхээр төлөвлөж байна.

2010 оны сүүлээр өрөмдсөн ZMD-121 цооногт огтолсон хүдэржилтийг тэлж шалгах зорилгоор ZMD-162 цооног өрөмдсөн. ZMD-162 цооногийг ZMD-121 цооноогоос 125 метрийн зайд баруун өмнө азимутын чиглэлд ZMD-121 цооног руу чиглүүлэн өрөмдсөн ба 286 метрт (269 метрийн босоо гүн) тайлагнасан хүдэржилтийг огтолсон. Үр дүнд 0.63% зэс болон 2.9 г/т мөнгөний агуулга бүхий 65 метрийн интервал огтолсон ба үүнд 1.25% зэс, 6.1 г/т мөнгөний агуулга бүхий 30 метрийн интервал багтаж байна. Хувирсан, хүдэржилт бүхий бүс нь цооногийн 238 метрээс 450 метр (цооногийн төгсгөл) хүртэл үргэлжилсэн ба дунд зэргээс хүчтэй калийн хувиралд орсон халькопирит болон пиритийн хүдэржилтээр тодорхойлогдож байна. Зэс болон мөнгөний хүдэржилт нь кварц кали-хээрийн жоншит гранитад байрлаж байгаа ба сульфидын агуулга 5-40% байна. Хөвийн Хар дахь зэсийн үр дүнгүүдэд тулгуурлан 2026 онд нарийвчилсан геофизик болон өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Тэрэг Уул зэс-алтны порфирийн төсөл

2025 оны 7 сарын 2-нд Эрдэнэ Ресурс нь 6,694 га Тэрэг Уул хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн 80 хүртэл хувийг эзэмших боломжийг авах гэрээ байгуулсан. Энэхүү талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдад байрладаг бөгөөд Тэрэг Уул Майнс ("ТУМ") ХХК эзэмшдэг. 2023 оны 4 сарын 5-нд олгогдсон энэхүү тусгай зөвшөөрөл нь нийт 12 жилийн хугацаатайгаас 3 дахь жилдээ хүчин төгөлдөр байгаа ба хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө Монгол Улсын ашигт малтмалын тухай хуулийн шаардлагыг биелүүлэн, ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой.

Тэрэг Уул тусгай зөвшөөрлийн талбай нь Оюу Толгойн ордоос баруун урд зүгт 10 км-т, хүдэржилтийн бүсийн дагуу Оюу толгой лицензийн өмнөд хилээс 5км зайд, Онтрэ/Оюу Толгойн хамтарсан Рэйлвэй зэс-алтны хэтийн төлөв бүхий талбайн ойролцоо оршдог. Порфирийн тренд нь Тэрэг Уулын талбайгаар дамжин урагш үргэлжилж, Тэрэг Уулаас урд зүгт 10 км-ийн зайд орших Хацавч Уул порфирийн төрлийн зэсийн хэтийн төлөв бүхий талбай хүрдэг.

2025 онд Эрдэнэ Ресурс нь тусгай зөвшөөрлийн талбайд соронзон, гравитацийн болон диполь-диполь индукцийн туйлшралын (IP) геофизикийн судалгааг гүйцэтгэсэн. Судалгаагаар хэд хэдэн геофизикийн аномаль тогтоогдсон бөгөөд эдгээрийг 2026 оны 2-р улиралд гүйцэтгэх анхан шатны өрөмдлөгөөр шалгахад төлөвлөж байна. Мөн геологийн зураглал, чулуулгийн дээжийн геохимийн судалгааг гүйцэтгэж, ойролцоогоор 2 км × 800 м хэмжээтэй, бүх чиглэлд нээлттэй алтны аномаль бүсийг тодорхойлсон. Чулуулгийн дээжийн үр дүнгээр 0.1 г/т-оос 4.1 г/т хүртэл алтны агуулга бүхий аномаль утгууд илэрсэн бөгөөд теллур, сурьма, висмут, молибден, мөнгө болон хар тугалгын агуулга өндөр байсан. Хүдэржилт нь шүлтлэг гранит суурь чулуулгийг огтлон байрлах, хагас параллель байрлалтай, огцом уналттай кварцын судлуудад агуулагдаж байгаа бөгөөд энэ нь интрузивтай холбоотой алтны судлын систем (IRGS) байж болзошгүй гэж тайлбарлагдсан бөгөөд энэхүү талбайг "BeB" хэмээн нэрлэсэн. Дээрх төрлийн ордуудын жишээнд Аляска дахь Fort Knox (>7 сая унц), Юкон дахь Brewery Creek (~1 сая унц) болон Dublin Gulch (~1.3 сая унц) зэрэг ордууд хамаардаг.

2025 оны хайгуул, геофизикийн судалгааны тодорхойлсон зорилтот талбайнуудыг шалгах анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөр (scout drilling)-ийг 2026 оны 2-р улиралд хэрэгжүүлж дуусгасан. Хөтөлбөрийн хүрээнд нийт 2,710 тууш метрийн 11 цооног өрөмдсөн. TUDH-01 болон TUDH-11 цооногуудыг хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн зүүн болон төв хэсэгт тодорхойлсон геофизикийн онцлог шинжүүдийг шалгахад чиглэсэн. Тэрэг Уул талбайд өмнө нь өрөмдлөг хийгдээгүй ба өрөмдсөн хөтөлбөр нь тус бүсийн газрын хэвлийн геологийн тогтоц болон стратиграфийн талаар анхан шатны мэдээлэл өгсөн. Дээрх цооногууд геологийн мэдээлэл өгөхөөс гадна TUDH-11 цооногт газрын гадаргаас 50 метрийн гүнээс эхлэн нүүрстөрөгчөөр баялаг, нүүрс агуулсан 110 метр зузаан, пропилит хувиралд орсон андезит дэх байгалийн зэс болон алтны аномаль бүхий хүдэржилтийг огтолсон.

Үлдсэн есөн цооногийг (TUDH-02–TUDH-10) тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсэгт өрөмдсөн бөгөөд 2025 онд цуглуулсан чулуулгийн дээжээс илэрсэн 4.1 г/т хүртэл алтны агуулгатай үр дүнг үргэлжлүүлэн шалгахад чиглэсэн. Энэхүү алтны хүдэржилт нь шүлтлэг гранитыг огтлон гарсан параллель кварцын судлуудтай (sheeted quartz veins) холбоотой. Шавраар дүүрсэн хагарлын улмаас 40 метрийн гүнд өрөмдлөгийг зогсоосон TUDH-02 цооноогоос бусад бүх цооногт алтны аномаль бүхий

хүдэржилт огтолсон ба 1.5 км-ийн суналын дагуу 0.1 г/т-оос дээш алтны агуулга бүхий хэд хэдэн 1 метрийн интервал тогтоогдсон. TUDH-03 цооногийн үр дүн хамгийн их сонирхол татсан бөгөөд цооногийн дагуу хамгийн зузаан тасралтгүй алтны хүдэржилт үргэлжилж, 0.17 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал огтолсон. Олон элементийн геохимийн шинжилгээгээр алтны хүдэржилт болон теллур (Te), висмут (Bi)-ийн өндөр агуулгын хооронд хүчтэй шууд хамаарал байгааг тогтоосон. Энэ нь интрузивтэй холбоотой алтны системд түгээмэл тохиолддог индикатор элементүүдийн (pathfinder elements) бүрдэлтэй нийцэж байна.

2026 оны 2-р хагас жилд геологичид Тэрэг Уул тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь хамарсан системчилсэн торлолын дагуу хөрсний геохимийн дээжлэлт хийж, 2-р улиралд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөс авсан өрмийн дээжид петрографийн болон нас тогтоох шинжилгээ хийхээр төлөвлөж байна.

Хөрөнгө оруулалт

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайнуудыг тодорхой хугацаанд тендерийн журмаар зарладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөв бүхий талбайнуудыг эрэмбэлсэн жагсаалттай. Энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад компани нь шууд болон Эрдэнэ Монгол ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтаар дамжуулан оролцохоор төлөвлөж байна. Түүнээс гадна хувийн өмчийн хуулийн этгээдүүдтэй хэлцэл хийх замаар тусгай зөвшөөрлийн талбайг эзэмших боломжуудыг судалсаар байна. Монгол Улсад урт хугацаанд ажилласан туршлагатай хайгуулын компанийн хувьд үнэт болон суурь металлын шинэ боломжуудыг сонгон үнэлсээр байх болно.

Үйл ажиллагааны хэлэлцүүлэг

2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын мэдээлэл

Доорх хүснэгтэд 2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд хайгуул болон үнэлгээний зардлыг харуулав.

6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар			
	2026	2025	Өөрчлөлт
Шууд зардал	712	163	549
Ажилтнуудын урамшууллын зардал	381	407	(26)
Хувьцаанд суурилсан урамшуулал	55	241	(186)
Хараат компаниас нөхөн төлөгдсөн :	(422)	(297)	(125)
	\$ 726	\$ 514	\$ 212

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд хайгуул, үнэлгээний зардал 726 доллар байсан бол 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд 514 доллар байв. 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын шууд зардал өмнөх оны мөн үеэс 549 доллароор өндөр байсан нь Эрдэнэ Ресурсийн 2025 оны 7 сард гэрээ байгуулсан Тэрэг Уул төслийн өрөмдлөгийн зардалтай холбоотой.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын ажилтнуудын цалин, урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 26 доллароор бага байв. Тайлант улиралд амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан хийсэн цалингийн тохируулгын нөлөө нь өмнөх оны мөн үед бүртгэсэн анхны алт олборлолттой холбоотой урамшууллын хуримтлагдсан зардлын нөлөөнөөс бага байсан нь энэхүү бууралтад нөлөөлсөн.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын мөнгөн бус хувьцаанд суурилсан урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 186 доллароор бага байв. Өмнөх оны мөн үед Эрдэнэ Монгол ХХК-ийн удирдах албан тушаалтнуудад хувьцааны опцион олгосон бол тайлант улиралд 2026 онд анх удаа олгосон хязгаарлалт бүхий хувьцааны нэгжүүдийн ("RSU") эзэмших эрх үүссэнтэй холбоотой зардал энэхүү бууралтыг хэсэгчлэн нөхсөн.

Компани болон хараат компани Эрдэнэ Монгол ХХК-ын хооронд байгуулсан гэрээний дагуу ЭМ нь геологи, техникийн үйлчилгээний төлбөрт жил бүр 1.375 сая ам.долларыг, холбогдох суутган татварыг хассан дүнгээр Компанид нөхөн төлдөг. 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд хараат компаниас нөхөн төлсөн зардал өмнөх оны мөн үеэс 125 доллароор өндөр

байв. Энэ нь гэрээний хүрээнд Эрдэнэ Монгол ХХК-ийн гүйцэтгэх ажил, оролцоо нэмэгдсэнтэй холбоотойгоор 2026 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжихээр гэрээний нөхцөлийг шинэчилсэнтэй холбоотой.

Дараах хүснэгтэд 2026 болон 2025 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын компанийн болон захиргааны зардлыг хураангуйлан үзүүлэв.

6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар			
	2026	2025	өөрчлөлт
Захиргааны үйлчилгээ	\$ 210	\$ 264	\$ (54)
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	92	57	35
Оффис ба бусад	49	24	25
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	97	123	(26)
Зохицуулагч байгууллагын төлбөр болон ТУЗ	137	91	46
Хувьцаанд суурилсан урамшуулал	50	88	(38)
Томилолтын зардал	41	12	29
	\$ 676	\$ 659	\$ 17

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд компанийн болон захиргааны зардал 676 доллар байсан бол 2025 оны мөн үед 659 доллар байв.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын захиргааны үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс 54 доллароор бага байв. Энэхүү бууралт нь тайлант улиралд амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан хийсэн цалингийн тохируулгын нөлөөнөөс өмнөх оны мөн үед бүртгэсэн анхны алт олборлохтой холбоотой урамшууллын хуримтлагдсан зардлын нөлөөгөөр бий болсон цалин, урамшууллын зардлын бууралт давсантай холбоотой.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хөрөнгө оруулагчидтай харилцах болон маркетингийн зардал өмнөх оны мөн үеэс 35 доллароор өндөр байсан нь тайлант хугацаанд хоёр нэмэлт хурал, арга хэмжээнд оролцсонтой холбоотой.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын оффис болон бусад зардал өмнөх оны мөн үеэс 25 доллароор өндөр байв. Энэ нь 2025 оны сүүлээр нэвтрүүлсэн ERP системтэй холбоотой компьютер, мэдээллийн технологийн зардал өссөн, даатгалын гэрээг шинэчлэхэд даатгалын зардал нэмэгдсэн, мөн өмнөх оны мөн үед түрээсийн хөнгөлөлт эдэлж байсантай харьцуулахад тайлант улиралд түрээсийн зардал өссөнтэй холбоотой.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын мэргэжлийн үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс 26 доллароор бага байсан нь голчлон компанийн зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаа буурсантай холбоотой.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд зохицуулагч байгууллагын төлбөр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардал өмнөх оны мөн үеэс 46 доллароор өндөр байсан нь 2026 оны эхээр ТУЗ-ийн гишүүдийн урамшууллын хөтөлбөрийг шинэчилсний дараа ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд мөнгөн бус хувьцаанд суурилсан урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 38 доллароор бага байв. Тайлант улиралд хязгаарлалт бүхий хувьцааны нэгжүүдийн (RSU) эзэмших эрх үүсэнтэй холбоотой зардал нь өмнөх оны мөн үед ТУЗ-ийн гишүүдийн урамшууллын хөтөлбөрийг шинэчилсэнтэй холбоотойгоор олгосон ирээдүйд олгогдох хувьцааны эрх (DSU)-ийн зардлаас бага байв. ИОХЭ-ийг олгосон үед нь зардлаар бүртгэдэг.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд томилолтын зардал өмнөх оны мөн үеэс 29 доллароор өндөр байсан нь дээр дурдсан хурал, арга хэмжээнүүдэд оролцохтой холбоотой томилолтын зардал нэмэгдсэнтэй холбоотой.

2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын мэдээлэл

Дараах хүснэгтэд 2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хайгуул, үнэлгээний зардлыг хураангуйлан үзүүлэв.

6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сар			
	2026	2025	Өөрчлөлт
Шууд зардал	\$ 877	\$ 273	604
Ажилтнуудын урамшууллын зардал	1,165	1,248	(83)
Хувьцаанд суурилсан урамшуулал	411	572	(161)
Хараат компаниас нөхөн төлөгдсөн	(836)	(605)	(231)
	\$ 1,617	\$ 1,488	\$ 129

Дараах хүснэгтэд 2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын компанийн болон захиргааны зардлыг хураангуйлан үзүүлэв.

6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сар			
	2026	2025	өөрчлөлт
Захиргааны үйлчилгээ	\$ 765	\$ 802	\$ (37)
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	234	133	101
Оффис ба бусад	91	62	29
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	218	212	6
Зохицуулагч байгууллагын төлбөр болон ТУЗ	356	191	165
Хувьцаанд суурилсан урамшуулал	346	688	(342)
Томилолтын зардал	110	71	39
	\$ 2,120	\$ 2,159	\$ (39)

Улирлын үр дүнгийн хураангуй

Нэгж хувьцаанад ногдох дүнгээс бусад үзүүлэлтийг мян.канад доллараар илэрхийлсэн.

	Санхүүгийн жил 2026			Санхүүгийн жил 2025			Санхүүгийн жил 2024	
	Q2	Q1	Q4	Q3	Q2	Q1	Q4	Q3
	6 сар	3 сар	12 сар	9 сар	6 сар	3 сар	12 сар	9 сар
Орлого (Алдагдал)	\$9,993	\$4,765	\$3,190	(\$2,749)	(\$4,122)	(\$4,501)	(\$6,558)	(\$1,688)
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	\$0.15	\$0.07	\$0.05	(\$0.04)	(\$0.07)	(\$0.07)	(\$0.03)	(\$0.03)
Нэгж хувьцаанд ногдох шингэрүүлсэн ашиг (алдагдал)	\$0.15	\$0.07	\$0.05	(\$0.04)	(\$0.07)	(\$0.07)	(\$0.03)	(\$0.03)
Нийт хөрөнгө	\$100,130	\$88,109	\$56,067	\$55,878	\$56,467	\$62,655	\$63,000	\$55,729

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд Компани 9,993 долларын цэвэр ашигтай байсан ба 2025 оны мөн улиралд 4,122 долларын цэвэр алдагдал хүлээсэн.

Монгол Улсад хэрэгжүүлдэг хайгуул, үнэлгээ болон хөгжүүлэлтийн хөтөлбөрүүдийн хугацаанаас шалтгаалан Компанийн зардал өмнөх хугацаанд улирал бүр харилцан адилгүй байсан. Харин Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны төслийн алт олборлолт эхэлсэнтэй холбоотойгоор цаашид Компанийн санхүүгийн үр дүнд уурхайн үйл ажиллагааны гүйцэтгэл хамгийн ихээр нөлөөлөх болно. Тайлант хугацааны хоорондын санхүүгийн үр дүнгийн хэлбэлзэлд нөлөөлөх өөр нөхцөл байдал Компанид одоогоор мэдэгдээгүй байна.

Төлбөр гүйцэтгэх чадвар болон хөрөнгийн эх үүсвэр

Энэхүү УХДШ гарах өдрөөр Компанийн бэлэн мөнгө \$26.8 сая кан.доллар, эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хасаж тооцсон ажлын капитал ойролцоогоор \$26.6 сая кан.доллар байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компанийн Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх (Хайгуул, хөгжүүлэлтийн төслүүд ба Үйл ажиллагааны хэлэлцүүлгээс танилцана уу), тэдгээрийг дэмжих захиргааны зардлуудыг санхүүжүүлэхэд зарцуулсан. Компанийн хөгжүүлэлт

болон хайгуулын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх боломж нь нэмэлт санхүүжилт татах чадвараас шууд хамаарна. Үүнд хувьцаа гаргах, ММС-тэй байгуулсан стратегийн хамтын ажиллагаа зэрэг түншлэл байгуулах, зээлийн санхүүжилт, хөрөнгө борлуулалт, опцион болон хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах зэрэг арга замууд багтана.

Компанийн орлогын эх үүсвэр хязгаарлагдмал байсан тул Компанийн мөнгөн гүйлгээнээс чиг хандлагыг тодорхойлох, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байдаг. Компани Эрдэнэ Монгол ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтаасаа ногдол ашиг авч эхлэх хүртэл хөгжүүлэлт болон хайгуулын хөтөлбөрүүдийг зээлийн санхүүжилт болон нэмэлт хувьцаа гаргах замаар санхүүжүүлж байна.

Энд дурдсанаас болон төлөвлөсөн зардлуудаас бусдаар Компанийн төлбөрийн чадвар болон хөрөнгийн эх үүсвэрийг одоогийн байдлаар эсхүл ойрын ирээдүйд мэдэгдэхүйц нэмэгдүүлэх буюу бууруулахад хүргэж болзошгүй аливаа чиг хандлага, эрэлт хэрэгцээ, үүрэг хариуцлага, үйл явдал эсхүл тодорхой бус нөхцөл байдал Компанид одоогоор мэдэгдээгүй байна.

Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл

2025 оны 6 сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн гаргасан болон эргэлтэд байгаа энгийн хувьцааг 6:1 харьцаагаар нэгтгэх (өөрөөр хэлбэл, нэгтгэлийн өмнөх 6 ширхэг хувьцаа нь нэгтгэлийн дараа 1 ширхэг хувьцаа болж тэнцэх) шийдвэрийг баталсан. Энэхүү нэгтгэлийн үр дүнд гаргасан болон эргэлтэд байгаа энгийн хувьцааны тоо 366,351,958 ширхэгээс 61,063,549 ширхэг болж буурсан бөгөөд 2025 оны 9 сарын 2-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Мөн хувьцааны опцион болон ирээдүйд олгогдох хувьцааны нэгжийг хувьцааны нэгтгэлийн харьцаанд нийцүүлэн тохируулсан. Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлөөс баталсан ОУНБС (IFRS)-ын дагуу энэхүү өөрчлөлтийг өмнөх хугацаанд буцаан тусган тооцсон бөгөөд үүний үр дүнд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан болон холбогдох тайлбаруудад тусгагдсан энгийн хувьцааны мэдээлэл, нэгж хувьцаанд ногдох үзүүлэлтүүд болон хувьцааны опционтой холбоотой мэдээлэл нь, өөрөөр заагаагүй бол, тайлагнасан бүх хугацаанд энэхүү хувьцааны нэгтгэлийг тусган харуулсан болно.

2026 оны 6 сарын 30-ны өдөр Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр ("NCIB")-ийг эхлүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд Компани 2026 оны 6 сарын 17-ны өдрийн байдлаар олон нийтийн эзэмшилд буй 49,386,538 ширхэг энгийн хувьцааны ойролцоогоор 10%-тай тэнцэх, нийт 4,900,000 хүртэлх энгийн хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох боломжтой. Хөтөлбөр нь 2027 оны 6 сарын 29-ний өдөр хүртэл хүчинтэй байх ба түүнээс өмнө хөтөлбөрийн хүрээнд худалдан авахаар төлөвлөсөн энгийн хувьцааны дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд тухайн өдрөөс өмнө дуусгавар болно. Тайлант улирал дууссаны дараах байдлаар Компани нийт 94,400 ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг дунджаар 5.21 долларын ханшаар эргүүлэн худалдан авч, хүчингүй болгосон.

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй

Гаргасан ба эргэлтэд буй хувьцаат капитал

	2026.08.12	2025.12.31
Гаргасан болон эргэлтэд буй хувьцааны тоо	65,498,644	61,874,216
Опцион	2,697,396	2,975,239
ИОХЭ	1,560,766	1,613,751
ХБХН	129,000	-
Нийт санхүүгийн хэрэгсэл	69,885,806	66,463,206

Гэрээгээр хүлээсэн үүрэг

Дараах хүснэгтэд 2026 оны 6 сарын 30-ны байдлаар Компанийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулав:

	Нийт	>1 жил	1-2 жил	2 жилээс илүү
Оффисын түрээс	\$85	\$32	\$32	\$21
Дансны өглөг ба бусад өр төлбөр	\$462	\$462	-	-
	\$547	\$494	\$32	\$21

Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг

MMC стратегийн түншлэл

2023 оны 1-р сард Эрдэнэ Ресурс нь MMC-тэй стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан. MMC нь \$40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-тай тэнцэх хувьцааг эзэмших нөхцөлтэй гэрээ байгуулсан. Энэхүү хөрөнгө оруулалтын нөхцөлүүд хангагдаж хөрвөх нөхцөлтэйгөөр хөрөнгө 2024 оны 1 сарын 23-ны өдөр эцэслэгдэн шилжсэн. Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-ийг эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн 5 км орчимд эзэмших тусгай зөвшөөрлүүд дээр 5%-ийн “Net smelter return” буюу “NSR” авах нөхцөлтэй.

Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор 2024 оны 2-р сарын 8-ны өдөр Эрдэнэ Ресурс нь MMC-тэй төслийн санхүүжилтийн гэрээг байгуулсан. Эрдэнэ Ресурс болон MMC нар нь Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК-ийг хамтран эзэмшдэг ба тус санхүүжилт нь MMC-ээс хувь эзэмшигчийн зээлийн нөхцөлөөр олгогдсон.

Баянхөндий төслийн бүтээн байгуулалтад хувь эзэмшигчийн зээл хэлбэрээр 50 сая ам.долларын санхүүжилт авсан ба үүнээс гадна 30 сая ам.долларыг зээлийн адил нөхцөлтэйгөөр олгох боломжтой. Зээлийн хугацаа нь олгогдсон өдрөөс таван жилийн хугацаатай ба жилийн 13.8%-ийн хүүтэй, улирал бүр төлөх төлбөрийн нөхцөлтэй. Эрдэнэ Монгол ХХК нь эхний дөрвөн хүүгийн төлбөрийг капиталжуулсан ба зээлийг хугацаа дуусахад бүрэн төлсөн байх нөхцөлтэй. 2026 оны 6 сарын 30-ны байдлаар капиталжуулсан хүүг багтаасан үлдэгдэл зээл 73 сая ам. доллар байна.

Зээлийн хүрээнд Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК дахь өөрийн эзэмшлийн 50% болон Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эзэмших “Net smelter return” буюу “NSR”-г барьцаа хөрөнгө болгоно. Зээлийн эргэн төлөгдөх хугацаанд талуудын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээний дагуу MMC давуу эрхийн саналтай байх бөгөөд Эрдэнэ Ресурсийн Зуун Мод төслийн хувьд тэргүүн ээлжид татгалзах эрх эдэлнэ. Мөн Эрдэнэ Ресурс нь зээлийн 50%-ийг худалдан авч, MMC-тэй адил нөхцөлөөр зээлдүүлэгч хувьцаа эзэмшигчийн хувиар оролцох эрхтэй.

Баянхөндий эргэлтийн хөрөнгийн зээл

2024 оны 12 сарын 4-нд Худалдаа хөгжлийн банктэй Баянхөндий төслийг ашиглалтад оруулахад эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр олгох санхүүжилтийн бичиг баримтад гарын үсэг зурсан. Энэ нь 50 сая ам.доллар хүртэл санхүүжилтийг 24 сарын хугацаатай олгох ба зээлийн эцсийн зургаан сарын хугацаанд сар бүр ижил хэмжээний эргэн төлөлт хийх нөхцөлтэй. Зээл нь жилийн 13.3%-ийн хүүтэй бөгөөд Баянхөндий төслийн боловсруулах үйлдвэрийн барилга, хөрөнгөөр баталгаажсан. 2025 оны 12 сарын 31-ний байдлаар Эрдэнэ Монгол нь 50 сая ам.долларын зээлийг хүлээн авсан. 2026 оны 4 сарын 23-нд баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулж, санхүүжилтийн хугацааг 2027 оны 12 сар хүртэл сунган, жилийн хүүгийн хэмжээг 11.8% болгон бууруулсан.

Роял Гоулд (“Royal Gold Inc”) Роялти гэрээ

Роял Гоулд (“Royal Gold Inc”) нь Эрдэнэ Ресурсийн батламжилсан Эрдэнэ Монгол ХХК-ийн Алтан Нар, Хөндий болон Улаан тусгай зөвшөөрлүүдэд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн (“NSR”) эрхийг эзэмшдэг. Роял Гоулд нь Алтан Нар болон Хөндий тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ирээдүйн роялти санхүүжилтэд хориг тавих эрхтэй.

Бусад

Компани Зуун Мод тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR Версамет Роялти Корп-д өгөх нөхцөлтэй. Эрдэнэ Ресурс нь олборлолтын тодорхой шатанд хүрснээр NSR-ын тодорхой хэсгийг буцаан худалдан авах эрхтэй.

Балансаас гадуурх зохицуулалт

Компани нь 2026 оны 6 сарын 30-ны байдлаар дээр дурдсанаас гадна батлан даалтын гэрээ, бусад байгууллагад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой болзошгүй үүрэг, үүсмэл хэрэгсэл буюу Компанид санхүүжилт, хөрвөх чадвар, зах зээлийн болон зээлийн эрсдэл учруулж болзошгүй аливаа үүрэг гэх мэт балансаас гадуурх аливаа зохицуулалт хийгээгүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж, тооцоолол

Санхүүгийн тайланг бэлтгэх явцад СТОУС-ын шаардлагаар Компанийн удирдлага нь тайлан болон холбогдох тодруулгуудтай холбоотойгоор материаллаг өөрчлөлт, нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалууд дэвшүүлэхийг шаарддаг. Үнэлэмж, тооцооллууд нь олон хүчин зүйлд үндэслэх бөгөөд түүхэн туршлага, одоогийн болон хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт мэдээллүүдийг ашигласан. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрөх магадлалтай.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйлсан тайлбар, дараагийн 12 сарын хугацаанд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд мэдэгдэхүйц залруулга хийхэд хүргэж болох дүгнэлт, тооцоолол, таамаглалыг 2025 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 2-т тусгасан. Дараах эх сурвалжуудыг онцолсон:

- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт дахь нөлөөллийг тодорхойлох;
- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралт

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт дахь нөлөөллийг тодорхойлох

Компанийн охин компаниуд дахь хувь хэмжээ нь нөлөөллийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай бөгөөд ингэснээр өмчийн бүртгэлийн аргаар бүртгэнэ. Удирдлага нь хууль ёсны эзэмшлийн хувь хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн шийдвэр гаргах үйл явцад дүн шинжилгээ хийх замаар дээрх нөлөөллийг тодорхойлдог. Эрдэнэ Ресурс нь 2023 оны 1-р сарын 10-ны өдөр Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтын хувь хэмжээг шилжүүлсэн даруйдаа удирдлага нь ЭМ олборлолтод чухал нөлөө үзүүлэх боломжтой гэдгээ тодорхойлж, энэ хөрөнгө оруулалтыг хувь нийлүүлэх аргын дагуу хараат компани гэж бүртгэсэн.

Стратегийн түншлэлийг эцэслэснээр, 2024 оны 1 сарын 23-нд Эрдэнэ Монгол ХХК нь 50%-ийн хувьцааг нэмж гарган, ММС-д эзэмшүүлсэн бөгөөд удирдлага нь дүн шинжилгээг шинэчилж, Компани нь Эрдэнэ Монгол ХХК-д нөлөөлөх нөлөөлөл өндөр байгааг баталгаажуулсан. Ингэснээр өмчийн бүртгэлийн аргаар хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт хэлбэрээр бүртгэж байна.

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралт:

Компани цэвэр хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрсний дараа үүссэн нэг буюу хэд хэдэн үйл явдлын үр дүнд үнэ цэний бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлэхийн тулд НББОУС 28 дагуу “Хараат аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан үйлдвэрлэл дэх хөрөнгө оруулалт”-ын удирдамжийг дагаж мөрддөг. Энэ дүгнэлтийг хийхдээ компанийн удирдлага цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэний бууралтын бодит нотолгоо, тухайлбал: хараат компанид учирч буй санхүүгийн томоохон хүндрэл, гэрээ зөрчсөн байдал, хараат компани төлбөрийн гүйлгээ хийх чадваргүй болох эсвэл хоцрох, цаашид дампуурах эрсдэл үүсэх, санхүүгийн шинэчилсэн өөрчлөн байгуулалтад орох, эсхүл хараат компанийн санхүүгийн хүндрэлийн улмаас түүнд хөрөнгө оруулах идэвхтэй зах зээл алга болох зэрэг олон хүчин зүйлийг үнэлнэ.

Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт

Шинээр мөрдсөн болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд

СТОУС 7 болон 9 - Санхүүгийн хэрэглүүр болон тодруулга

2024 оны 5 сараас эхлэн НББОУС3 (“IASB”) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон үнэлгээнд (СТОУС 7 болон СТОУС 9) нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдээр СТОУС 9-ийн ангилал болон үнэлгээ, СТОУС 7-ийн холбогдох тодруулгын шаардлагыг шинэчилсэн. НББОУС3-өөс зарим санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, данснаас хасах огноог тодруулж, цахим төлбөрийн системийг ашиглан санхүүгийн өр төлбөрийг барагдуулахтай холбоотой шаардлагад өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлт нь 2026 оны 1 сарын 1 болон түүнээс хойш эхлэх жилийн тайлант үеүүдэд хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь дээрх стандартыг 2026 оны 1 сарын 1-ээс ирээдүйд мөрдөх зарчмаар хэрэглэсэн ба санхүүгийн тайланд нөлөө үзүүлээгүй.

Доорх стандартыг нягтлан бодох бүртгэлд мөрдөгдөж эхлээгүй.

СТОУС 18 – Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга

2024 оны 4 сарын 9-нд НББОУС3 (“IASB”) нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгыг орлох СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга танилцуулсан. СТОУС 18 нь ашиг алдагдлын тайланд ангилал, тодорхойлсон дэд нийлбэр нэмж, удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүрүүдийн тодруулга, санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэх, задлахыг

сайжруулах шаардлагыг тусгасан. СТОУС 18-ын хүрээнд НББОУС 7-д нэмэлт өөрчлөлт оруулсан ба аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны ашгийн дэд дүнг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд бус аргаар тайлагнах эхлэлийн үзүүлэлт болгон ашиглах, мөн төлсөн болон хүлээн авсан хүү, ногдол ашгийг толилуулах сонголтуудыг хасах шаардлагатай болсон. Үүнтэй адил НББОУС 33 “Нэгж хувьцаанд ногдох ашиг”-т нэмэлт өөрчлөлт оруулж, СТОУС 18-д нийт эсвэл дэд нийлбэрийн тоон үзүүлэлтээр ашиг, алдагдлын тайлангийн бусад бүрэлдэхүүн хэсгийг ашиглан нэгж хувьцаанд ногдох ашгийн нэмэлт мэдээллийг тодруулахыг зөвшөөрсөн. СТОУС 18 нь 2027 оны 1 сарын 1-ээс эхлэн тайлангийн үед хүчин төгөлдөр болох ба буцаан мөрдөх зарчмаар хэрэглэнэ. Компани нь дээрх стандартыг мөрдөж эхэлснээр санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна.

Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл

Санхүүгийн хэрэглүүр

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр хэмжсэн, эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгад мэдээлсэн хөрөнгө болон өр төлбөрийг бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан өгөгдлийн ач холбогдлыг тусгасан бодит үнэ цэнийн шатлалын дагуу ангилна. Үүнд:

Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх ижил хөрөнгө эсвэл өр төлбөрийн үнийн санал (тохируулаагүй)

Түвшин 2: Түвшин 1-д багтсан үнийн саналаас бусад, тухайн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хувьд шууд (жишээлбэл, үнэ хэлбэрээр) эсвэл шууд бусаар (жишээлбэл, үнээс үүсгэсэн) ажиглах боломжтой өгөгдөл;

Түвшин 3: Тухайн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хувьд ажиглах боломжтой зах зээлийн өгөгдөлд үндэслээгүй буюу ажиглагдахгүй өгөгдөл.

Бодит үнэ цэн

2025 болон 2026 оны 6 сарын 30-ны өдөр дуусгавар болсон гурван сарын хугацаанд 1, 2, 3-р түвшинд ангилсан хөрөнгө, өр төлбөрийн хооронд шилжүүлэг хийгдээгүй. Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн нь богино хугацаанд санхүүгийн хэрэглүүрийн хугацаа дуусахад дансны үнэ цэнтэй ойролцоо байна.

Зээлийн эрсдэл

Компани нь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын томоохон санхүүгийн институтэд хадгалуулж, бэлэн мөнгөний эрсдэлийг бууруулах боломжтой гэж Компанийн удирдлага үздэг. 2026 оны 6 сарын 30-ны байдлаар бэлэн мөнгөний үлдэгдлийн 1% буюу \$126 нь Канад Улсаас гадна банкуудад хадгалагдаж байна (2025.12.31 - \$159 буюу 3%).

Хөрвөх чадварын эрсдэл

Компанийн хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь мөнгө эсвэл бусад санхүүгийн хөрөнгө шилжүүлэх замаар барагдуулах санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд Компани хүндрэлтэй тулгарах эрсдэлийг хэлнэ. Компани нь хөрвөх чадварын эрсдэлийг удирдахдаа хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд өр төлбөрийг хугацаанд нь барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадвартай байхыг хангах бодлого баримталдаг. Компанийн бүх санхүүгийн өр төлбөрийг ирэх арван хоёр сарын дотор барагдуулахаар хүлээгдэж байна.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

Хүүгийн эрсдэл

Компани нь илүүдэл бэлэн мөнгийг хүүгийн орлого бүхий хадгаламжийн дансанд байршуулж байгаа нь хүүгийн эрсдэлд өртөх магадлалтай.

Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны валют нь канад доллар бөгөөд охин, хараат компанийн үйл ажиллагааны валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллароор зардал гаргадаг. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллароор илэрхийлэгдэх бэлэн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, худалдаа болон бусад өглөг багтаж байна.

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь цэвэр алдагдал болон бусад дэлгэрэнгүй алдагдал (орлого), мөн хуримтлагдсан алдагдалд \$52 долларын нөлөө үзүүлэх магадлалтай (2025.12.31 - \$46).

Төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь цэвэр алдагдал болон бусад дэлгэрэнгүй алдагдал (орлого), мөн хуримтлагдсан алдагдалд ойролцоогоор \$3 долларын нөлөө үзүүлэх магадлалтай (2025.12.31 - \$2).

Үнийн эрсдэл

Компани нь тодорхой ашиггүй тул түүхий эдтэй холбоотойгоос бусад санхүүгийн хэрэгсэл, хайгуул, олборлолтын салбар дахь компаниудад нөлөөлдөг үнийн хэлбэлзэл, үнийн шууд эрсдэлд өртөхгүй.

Бусад эрсдэлүүд

Компани нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа голчлон хайгуулын үр дүн, тусгай зөвшөөрөл, санхүүжилттэй холбоотой эрсдэлтэй тулгардаг, түүнээс гадна металл болон түүхий эдийн үнэтэй холбоотой эрсдэл, тодорхой бус байдал үүсэх боломжтой. Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйл ажиллагааны хөгжүүлэлт нь олон эрсдэл дагуулдаг бөгөөд дийлэнх нь Компанийн хяналтаас давсан байдаг. Компани нь дэд бүтэц сул хөгжсөн алслагдмал байршилд үйл ажиллагаа явуулдгаас гадна хайгуул, ашиглалтын энгийн эрсдэлүүдтэй тулгарч байдаг. Эдгээр эрсдэлүүдийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR+ www.sedarplus.ca-д байрлах Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс танилцах боломжтой.

Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт

Канадын үнэт цаасны зохицуулалтын 52-109 журмын дагуу санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх захирал (ГЗ), Санхүү хариуцсан захирал (СХЗ)-ыг багтаасан Эрдэнэ Ресурсийн удирдах баг (хамтад нь “Удирдах баг” гэх) нь 2026 оны 6 сарын 30-аар санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж, компани болон түүний охин компаниудтай холбоотой материаллаг мэдээллийг шаардлагатай талд мэдүүлж, үнэн зөв бүрэн тодруулах боломжтой гэсэн баталгааг гаргахад хангалттай гэж дүгнэсэн.

ГЗ болон СХЗ-ын хамтаар компанийн удирдлага нь санхүүгийн тайлагналд дотоод хяналтыг бий болгох, хангаж ажиллах үүрэгтэй. Санхүүгийн тайлагналд тавих Эрдэнэ Ресурсийн дотоод хяналт (аудит) нь санхүүгийн тайлагналын найдвартай байдлыг хангаж, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд анхаарна.

Удирдлага нь 2026 оны 6 сарын 30-ны байдлаар Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтын хэрэгжилт, үр нөлөөг үнэлсэн. Ийнхүү үнэлэхдээ Удирдлага нь (“Committee of Sponsoring Organizations of the Treadway Commission”) “Дотоод хяналт - нэгдсэн зохицуулалтын орчин (2013)” гэх тайланд тогтоосон шалгууруудыг ашигласан. Үнэлгээгээр гол эрсдэлтэй салбаруудын хяналтыг шалгаж, эдгээр хяналтуудын хэрэгжилтийг үнэлж, үр нөлөөг нь тодорхойлох зорилгоор тэдгээр хяналтуудыг туршиж, үр дүнг нь хянаж, улмаар нэгдсэн дүгнэлт гаргасан.

Удирдлагын үнэлгээнд үндэслэн ГЗ болон СХЗ нар 2026 оны 6 сарын 30-ны өдрөөр Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналт болон материаллаг сул тал нь санхүүгийн тайлагналын үнэн зөв, найдвартай байдлыг хангах, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд үр нөлөөтэй байна гэж дүгнэсэн.

Үр дүнтэй хэмээн тодорхойлсон систем нь санхүүгийн тайлангийн бэлтгэл, танилцуулгатай холбоотойгоор баталгааг зөвхөн тодорхой хэмжээнд өгөх боломжтой. Түүнчлэн, ирээдүйн үр дүнтэй байдлын үнэлгээний төсөөлөл нь нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хяналт буурах, эсвэл бодлого, дүрэм журмын хэрэгжилт муудах эрсдэлүүд бий.

Мэргэшсэн этгээд

Энэхүү тайланд тусгасан Баянхөндий, Хар Морь, Алтан Нар болон Улаан ордын эрдсийн нөөцийн тооцоолол, үүний дотор Баянхөндий болон Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцоололтой холбоотой энэхүү тайлангийн хавсралтуудад тусгасан мэдээлэл нь SLR Advisory Asia Limited-ийн үндсэн ажилтан бөгөөд Австралийн Геошинжлэх Ухааны Хүрээлэнгийн гишүүн Бат-Очир овогтой Оюунбат нэгтгэн боловсруулж, хянан баталгаажуулсан. Б.Оюунбат нь ордуудын хүдэржилтийн хэв шинж, ордын төрөл болон гүйцэтгэсэн ажлын чиглэлээр өндөр туршлагатай бөгөөд NI 43-101 (National Instrument 43-101) стандартад тодорхойлсон Мэргэшсэн мэргэжилтэн (Qualified Person)-ий шаардлагыг хангасан. Б.Оюунбат нь энэхүү ажлыг гүйцэтгэхэд Эрдэнэ Ресурстай холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдал байгаа талаар мэдэгдээгүй болно.

Жон Лёнс (FAusIMM) нь NI 43-101 стандартын шаардлага хангасан мэргэшсэн этгээд бөгөөд Компанийн Баянхөндий уурхайн үйл ажиллагаатай холбоотой техникийн мэдээллийг хянаж, баталгаажуулсан. Жон Лёнс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн Өсөлт, хөгжил хариуцсан захирал бөгөөд Компанийн хараат албан тушаалтанд багтана.

Петер Далтон, P. Geo, (Нова Скошиа) нь NI 43-101 стандартын шаардлага хангасан мэргэшсэн этгээд бөгөөд Компанийн хайгуулын бүх геологийн хөтөлбөрийг удирдан чиглүүлнэ. Дээжийг Монгол Улсын Улаанбаатар хот эсвэл БНХАУ-ын Тяньжинд байрлах Эс Жи Эс лаборатори ("SGS Laboratories"), Улаанбаатар хот дахь Геологийн төв лаборатори, Канадын Бритиш Колумбийн муж дахь Блю Коуст Рисерч Лтд ("Blue Coast Research Ltd") эсвэл Канадын Ванкувер хотод төвтэй ALS Chemex лабораторид тус тус шинжлүүлдэг. Эс Жи Эс лаборатори, Геологийн төв лаборатори, ALS Chemex лабораторийн дотоод хяналтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэдэг.

Энэхүү УХДШ-д толилуулсан Компанийн эзэмшиж буй ашигт малтмалын төслүүдийн шинжлэх ухааны болон техникийн мэдээллийг Компанийн мэргэшсэн мэргэжилтэн Петер Далтон (P. Geo) хянан баталсан бөгөөд Компанийн хараат албан тушаалтанд багтана.

Бусад мэдээлэл

Компанийн талаарх нэмэлт мэдээллийг SEDAR+ www.sedarplus.ca хаяг болон www.erdene.com хаяг дахь Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс үзэх боломжтой.

Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн тайлангийн орчуулга болно. Англи болон монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчил гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

Хавсралт А – Баянхөндий ордын эрдсийн нөөцийн тооцооллыг дэмжих техникийн мэдээлэл

SLR нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчлэн боловсруулсан бөгөөд дараах хавсралтад 2026 оны 7 сарын 1-ний өдрийн Баянхөндий ордын эрдсийн нөөцийн мэдэгдэлтэй холбоотой техникийн мэдээллийг тусгав.

Хавсралт В – Хар Морь ордын эрдсийн нөөцийн тооцооллыг дэмжих техникийн мэдээлэл

SLR нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчлэн боловсруулсан бөгөөд дараах хавсралтад 2026 оны 7 сарын 1-ний өдрийн Хар Морь ордын эрдсийн нөөцийн мэдэгдэлтэй холбоотой техникийн мэдээллийг тусгав.